|                    | Үүнээс: Ирээдүй өв санд                                                                                                                                                                                                  | 240,277.2                 |
| 3                  | <b>Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд</b>                                                                                                                                                                        | <b>156,028.9</b>          |
|                    | Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 10.3-т заасан Хуримтлалын сангийн хөрөнгө оруулалтын орлого                                                                                                                      | 156,028.9                 |
|                    | Үүнээс: Хуримтлалын санд                                                                                                                                                                                                 | 156,028.9                 |
| <b>Нийт орлого</b> |                                                                                                                                                                                                                          | <b>2,956,123.0</b>        |

Дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 61  
Татгалзсан: 36  
Бүгд: 97  
62.9 хувийн саналаар дэмжигдлээ.

**4 дүгээр зүйл.** Ирээдүйн өв сангийн үлдэгдэл 2025 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн байдлаар 4,706,102.4 сая төгрөг байна. Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 11 дүгээр зүйлд заасны дагуу Ирээдүйн өв санд 2026 оны төсвийн жилд 2,427,193.1 сая төгрөгийг хуримтлуулна.

Дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 62

Татгалзсан: 35  
Бүгд: 97  
63.9 хувийн саналаар дэмжигдлээ.

**5 дугаар зүйл.** Хуримтлалын сангийн үлдэгдэл 2025 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн байдлаар 654,424.3 сая төгрөг байна. Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 10, 11 дүгээр зүйлд заасны дагуу Хуримтлалын санд 2026 оны төсвийн жилд 528,929.9 сая төгрөгийг хуримтлуулна.

Дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 63  
Татгалзсан: 34  
Бүгд: 97  
64.9 хувийн саналаар дэмжигдлээ.

**6 дугаар зүйл.** Энэ хуулийг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 64  
Татгалзсан: 33  
Бүгд: 97  
66.0 хувийн саналаар дэмжигдлээ.

**Б.Пүрэвдорж:** Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслийг бүхэлд нь эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 65  
Татгалзсан: 32  
Бүгд: 97  
67.0 хувь буюу нийт гишүүдийн олонхын саналаар хууль батлагдлаа.

**Б.Пүрэвдорж:**

## НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ

### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

#### 1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь Нийгмийн даатгалын санд 2026 оны төсвийн жилд төвлөрүүлэх орлого, зарцуулах төсвийн хэмжээ, төсөв зарцуулах эрх олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 63  
Татгалзсан: 34  
Бүгд: 97  
64.9 хувийн саналаар дэмжигдлээ.

**Б.Пүрэвдорж: 2 дугаар зүйл.Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн хууль тогтоомж**

2.1.Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн хууль тогтоомж нь Төсвийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

Дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 65  
Татгалзсан: 32  
Бүгд: 97  
67.0 хувийн саналаар дэмжигдлээ.

**Б.Пүрэвдорж:**

**ХОЁРДУГААР БҮЛЭГ**

**3 дугаар зүйл.**Нийгмийн даатгалын санд 2026 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч доор дурдсан хэмжээтэй орлогыг төвлөрүүлнэ:

| Д/д                | Орлогын төрөл                                                                                                        | Дүн<br>/сая<br>төгрөгөөр/ |
|--------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------|
| 1                  | <b>Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд</b>                                                                   | <b>7,824,713.5</b>        |
|                    | 1.1 Ажил олгогчийн төлөх шимтгэл                                                                                     | 3,252,511.9               |
|                    | 1.2 Ажиллагчдаас төлөх шимтгэл                                                                                       | 2,535,805.9               |
|                    | 1.3 Эхийн хүүхэд асрах чөлөөтэй хугацааны шимтгэл                                                                    | 17,305.6                  |
|                    | 1.4 Цаатан иргэдийн нийгмийн даатгалын шимтгэл                                                                       | 132.6                     |
|                    | 1.5 Сайн дурын даатгуулагчаас төлөх шимтгэл                                                                          | 229,785.9                 |
|                    | 1.6 Гадаадад хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа иргэдийн төлөх шимтгэл                                             | 3,121.0                   |
|                    | 1.7 Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон даатгуулагчийн төлөх шимтгэл | 2,804.8                   |
|                    | 1.8 Бусад орлого                                                                                                     | 158,672.4                 |
|                    | 1.9 Төр хариуцах иргэдийн тэтгэвэр болон шимтгэлийн хөнгөлөлтийн татаас                                              | 1,624,573.3               |
| <b>Нийт орлого</b> |                                                                                                                      | <b>7,824,713.5</b>        |

Дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 63  
Татгалзсан: 34  
Бүгд: 97  
66.0 хувийн саналаар дэмжигдлээ.

**Б.Пүрэвдорж: 4 дүгээр зүйл.**Нийгмийн даатгалын сангийн төсөвт 2026 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч доор дурдсан хэмжээтэй эргэн төлөх төлбөрийг төлнө:

| Д/д | Төсвийн ерөнхийлөн захирагч                 | Дүн<br>/сая төгрөгөөр/ |
|-----|---------------------------------------------|------------------------|
| 1   | Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд | 67,232.2               |

Дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 63  
Татгалзсан: 34  
Бүгд: 97  
64.9 хувийн саналаар дэмжигдлээ.

**Б.Пүрэвдорж: 5 дугаар зүйл.**2026 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч доор дурдсан хэмжээтэй төсвийг зарцуулна:

| Д/д                 | Зарлагын төрөл                                                     | Дүн<br>/сая<br>төгрөгөөр/ |
|---------------------|--------------------------------------------------------------------|---------------------------|
| 1                   | <b>Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд</b>                 | <b>6,584,769.2</b>        |
|                     | 1.1 Тэтгэврийн даатгалын сан                                       | 6,003,442.3               |
|                     | 1.2 Тэтгэмжийн даатгалын сан                                       | 320,562.5                 |
|                     | 1.3 Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сан | 70,792.5                  |
|                     | 1.4 Ажилгүйдлийн даатгалын сан                                     | 189,971.9                 |
| <b>Нийт зарлага</b> |                                                                    | <b>6,584,769.2</b>        |

Дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 66  
Татгалзсан: 31  
Бүгд: 97  
68.0 хувийн саналаар дэмжигдлээ.

**Б.Пүрэвдорж: 6 дугаар зүйл.**Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлээс Засгийн газрын урт хугацаат /нэг жил болон түүнээс дээш/ бонд, Монголбанкны үнэт цаас худалдан авахад зарцуулах хөрөнгийн дээд хэмжээг 300,000.0 сая төгрөгөөр баталсугай.

Дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 63

Татгалзсан: 34  
Бүгд: 97  
64.9 хувийн саналаар дэмжигдлээ.

**Б.Пүрэвдорж: 7 дугаар зүйл.** Энэ хуулийг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 67  
Татгалзсан: 30  
Бүгд: 97  
69.1 хувийн саналаар дэмжигдлээ.

**Б.Пүрэвдорж:** Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслийг бүхэлд нь эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 68  
Татгалзсан: 29  
Бүгд: 97  
70.1 хувь буюу нийт гишүүдийн олонхын саналаар хууль батлагдлаа.

**Б.Пүрэвдорж:**

## **ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ**

### **НЭГДҮГЭЭР БҮЛЭГ**

### **НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

#### **1 дүгээр зүйл. Хуулийн зорилт**

1.1. Энэ хуулийн зорилт нь Эрүүл мэндийн даатгалын санд 2026 оны төсвийн жилд төвлөрүүлэх орлого, зарцуулах төсвийн хэмжээ, төсөв зарцуулах эрх олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 62  
Татгалзсан: 35  
Бүгд: 97  
63.9 хувийн саналаар дэмжигдлээ.

**Б.Пүрэвдорж: 2 дугаар зүйл.** Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн хууль тогтоомж

2.1. Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн хууль тогтоомж нь Төсвийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Эрүүл мэндийн

даатгалын тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

Дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 67  
Татгалзсан: 30  
Бүгд: 97  
69.0 хувийн саналаар дэмжигдлээ.

**Б.Пүрэвдорж:**

### ХОЁРДУГААР БҮЛЭГ

#### ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА

**3 дугаар зүйл.** Эрүүл мэндийн даатгалын санд 2026 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч доор дурдсан хэмжээтэй орлогыг төвлөрүүлнэ:

| Д/д                | Орлогын төрөл             |                                                                                 | Дүн<br>/сая төгрөгөөр/ |
|--------------------|---------------------------|---------------------------------------------------------------------------------|------------------------|
| 1                  | <b>Эрүүл мэндийн сайд</b> |                                                                                 | <b>2,746,739.5</b>     |
|                    | 1.1                       | Ажил олгогч, даатгуулагчаас төлөх шимтгэл                                       | 1,190,982.8            |
|                    | 1.2                       | Төрөөс эрүүл мэндийн даатгалыг нь хариуцах иргэдийн улсын төсвөөс төлөх шимтгэл | 431,181.3              |
|                    | 1.3                       | Төр хариуцах тусламж, үйлчилгээний санхүүжилт                                   | 1,067,035.4            |
|                    | 1.4                       | Бусад даатгуулагчаас төлөх шимтгэл                                              | 57,540.1               |
| <b>Нийт орлого</b> |                           |                                                                                 | <b>2,746,739.5</b>     |

Дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 66  
Татгалзсан: 31  
Бүгд: 97  
68.0 хувийн саналаар дэмжигдлээ.

**Б.Пүрэвдорж: 4 дүгээр зүйл.** Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөвт 2026 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч доор дурдсан хэмжээтэй эргэн төлөх төлбөрийг төлнө:

| Д/д | Төсвийн ерөнхийлөн захирагч | Дүн<br>/сая төгрөгөөр/ |
|-----|-----------------------------|------------------------|
| 1   | <b>Эрүүл мэндийн сайд</b>   | <b>75,500.0</b>        |

Дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 68  
Татгалзсан: 29  
Бүгд: 97

70.1 хувийн саналаар дэмжигдлээ.

**Б.Пүрэвдорж: 5 дугаар зүйл.**2026 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагчид доор дурдсан төсвийг зарцуулна:

| Д/д                 | Зарлагын төрөл            |                                                                           | Дүн<br>/сая<br>төгрөгөөр/ |
|---------------------|---------------------------|---------------------------------------------------------------------------|---------------------------|
| 1                   | <b>Эрүүл мэндийн сайд</b> |                                                                           | <b>2,458,751.5</b>        |
|                     | 1.1                       | Эрүүл мэндийн даатгалын сангаас хариуцах тусламж, үйлчилгээний санхүүжилт | 2,275,447.3               |
|                     | 1.2                       | Эмийн санд үнийн хөнгөлөлт                                                | 169,774.4                 |
|                     | 1.3                       | Үйл ажиллагааны урсгал зардал                                             | 13,529.7                  |
| <b>Нийт зарлага</b> |                           |                                                                           | <b>2,458,751.5</b>        |

Дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 67

Татгалзсан: 30

Бүгд: 97

69.1 хувийн саналаар дэмжигдлээ.

**Б.Пүрэвдорж: 6 дугаар зүйл.**Энэ хуулийг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 67

Татгалзсан: 30

Бүгд: 97

69.1 хувийн саналаар дэмжигдлээ.

**Б.Пүрэвдорж:** Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслийг бүхэлд нь эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 69

Татгалзсан: 28

Бүгд: 97

71.1 хувь буюу нийт гишүүдийн олонхын саналаар хууль батлагдлаа.

Улсын Их Хурлын дэд дарга Б.Пүрэвдорж хуулийн төслүүд батлагдсантай холбогдуулан үг хэлэв.

Уг асуудлыг 17 цаг 50 минутад хэлэлцэж дуусав.

**Дөрөв.***“Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн Л.Оюун-Эрдэнэ нарын 33 гишүүн 2025.10.06-ны өдөр өргөн мэдүүлсэн, үргэлжилнэ/*

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Байнгын хороодын газрын дарга Ч.Дондогмаа нар байлцав.

Улсын Их Хурлын дэд дарга Б.Пүрэвдорж өмнөх хуралдаанаар “Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулж дэмжигдээгүй нь Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн хууль зөрчигдөөгүй тухай мэдэгдэж, өмнөх санал хураалтыг хүчинтэйд тооцож дахин санал хураалт явуулаагүй болно.

Мөн Улсын Их Хурлын гишүүн Д.Пүрэвдаваагийн дахин санал хураалгах шаардлагатай гэсэн горимын саналыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, 7 дугаар зүйлийн 7.5, 10 дугаар зүйлийн 10.1 дэх заалтуудыг үндэслэн хүчингүйд тооцож байгаа талаар мэдэгдэв.

*Уг асуудлыг 17 цаг 55 минутад хэлэлцэж дуусав.*

***Тав.Монгол Улсын Их Хурлын дэд даргыг огцруулах тухай асуудал /үргэлжилнэ/***

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Байнгын хороодын газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул нар байлцав.

Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга О.Цогтгэрэл завсарлагын хугацаа дууссан тухай мэдэгдэж, үг хэлэв.

**Б.Пүрэвдорж:** Монгол Улсын Их Хурлын дэд дарга Хүрэлбаатарын Булгантуяаг Улсын Их Хурлын дэд даргаас огцруулахыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

|                                  |    |
|----------------------------------|----|
| Зөвшөөрсөн:                      | 66 |
| Татгалзсан:                      | 33 |
| Бүгд:                            | 99 |
| 66.7 хувийн саналаар дэмжигдлээ. |    |

Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд, Д.Цогтбаатар нарыг дэмжсэнээр тооцож, 68.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т тус тус заасны дагуу санал хураалтад оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул “Монгол Улсын Их Хурлын дэд даргыг огцруулах тухай” тогтоол баталсанд тооцлоо.

Улсын Их Хурлын дэд дарга Б.Пүрэвдорж “Монгол Улсын Их Хурлын дэд даргыг огцруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан

асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./18:04/

*Уг асуудлыг 18 цаг 05 минутад хэлэлцэж дуусав.*

***Зургаа.Монгол Улсын Их Хурлын дэд даргыг сонгох тухай асуудал***

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Байнгын хороодын газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул нар байлцав.

**Б.Пүрэвдорж:** Монгол Улсын Их Хурлын дэд даргаар Жадамбын Бат-Эрдэнийг сонгох саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 78  
Татгалзсан: 22  
Бүгд: 100  
78.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Р.Батболд, Ж.Баярмаа, П.Батчимэг, Ж.Батсуурь, Б.Хэрлэн нарыг дэмжсэнээр тооцож, 83.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т тус тус заасны дагуу санал хураалтад оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул “Улсын Их Хурлын дэд даргыг сонгох тухай” тогтоол баталсанд тооцлоо.

Улсын Их Хурлын дэд дарга Б.Пүрэвдорж “Улсын Их Хурлын дэд даргыг сонгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./18:09/

*Хуралдааныг 18 цаг 10 минутаас 18 цаг 48 минутад түр завсарлуулав.*

***Долоо. “Монгол Улсын Их Хурлын даргын үүрэг гүйцэтгүүлэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл***

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Б.Баясах нар байлцав.

**Б.Пүрэвдорж:** “Монгол Улсын Их Хурлын дэд даргын үүрэг гүйцэтгүүлэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 79  
Татгалзсан: 21  
Бүгд: 100  
79.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын дэд дарга Б.Пүрэвдоржийг дэмжсэнээр тооцож, 80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т тус тус заасны дагуу санал хураалтад оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул “Улсын Их Хурлын дэд даргыг сонгох тухай” тогтоол баталсанд тооцлоо.

Улсын Их Хурлын дэд дарга Б.Пүрэвдорж “Монгол Улсын Их Хурлын даргын үүрэг гүйцэтгүүлэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./18:56/

*Уг асуудлыг 18 цаг 56 минутад хэлэлцэж дуусав.*

***Найм.Засгийн газрын гишүүнийг огцруулах, томилох асуудлыг танилцуулах***

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул нар байлцав.

Монгол Улсын Засгийн газрын гишүүнийг огцруулах, томилох саналыг Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Тувааны тавьсан асуултад Монгол Улсын Шадар сайд Х.Ганхуяг хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, Л.Мөнхбаясгалан, Л.Энхнасан, Да.Цогтбаатар, Б.Бейсен нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд Монгол Улсын Засгийн газрын гишүүнийг огцруулах, томилох тухай Монгол Улсын Ерөнхий сайдын танилцуулгыг сонслоо.

*Уг асуудлыг 19 цаг 22 минутад хэлэлцэж дуусав.*

*Чуулганы нэгдсэн хуралдааныг Засгийн газрын гишүүдийн тангараг өргөх ёслолын ажиллагааны бэлтгэлийг хангахаар 19 цаг 22 минутаас 19 цаг 33 минутад түр завсарлуулав.*

***Ес.Засгийн газрын гишүүн тангараг өргөх ёслолын ажиллагаа***

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул нар байлцав.

Засгийн газрын гишүүний тангараг өргөх ёслолын ажиллагаатай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар, Улсын Их Хурлын

гишүүн, Засгийн газрын гишүүн Х.Ганхуяг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Б.Баясах нар байлцав.

“Монгол Улсын Засгийн газрын гишүүнийг томилох тухай” Монгол Улсын Ерөнхий сайдын захирамжийг Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар танилцуулав.

Ёслолын ажиллагааг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Төрийн ёслол, хамтын ажиллагааны газрын дарга Э.Одмөнх, референт Д.Батжаргал, шинжээч Б.Мөнхбилгүүн нар зохион байгуулав.

“Их хуралдай” танхимын индрийн баруун талд Төрийн далбаа, танхимын голд Үндсэн хууль, тангаргийн бичиг, үзэг тавьж тусгайлан бэлтгэсэн ширээг сандлын хамт Засгийн газрын гишүүний тангараг өргөх ёслолд зориулан бэлтгэн байрлуулж, Төрийн сүлдний баруун талд хүндэт харуул зогссон байлаа.

Монгол Улсын Засгийн газрын гишүүний тангараг өргөх журмын дагуу тангараг өргөх ёслолын ажиллагаа эхлэв.

Улсын Их Хурлын дэд дарга Б.Пүрэвдорж Засгийн газрын гишүүний нэрийг дуудав.

Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын Шадар сайд Х.Ганхуяг Монгол Улсын Төрийн сүлд рүү харан зогсон уншиж, Тангараг өргөсний дараа Төрийн сүлдэнд мэхийн ёсолж, Төрийн далбааны өмнө баруун өвдөг мэхийн сууж адис аван, “Их хуралдай” танхимын голд байрлуулсан ширээнд сууж, тангаргийн бичигт гарын үсэг зурж, Улсын Их Хурлын дэд даргад тангаргийн бичгээ гардуулсны дараа Ерөнхий сайд Засгийн газрын гишүүний үнэмлэх, энгэрийн тэмдгийг гардуулав.

Ерөнхий сайд Г.Занданшатар Засгийн газрын гишүүнд үнэмлэх, энгэрийн тэмдгийг гардуулсны дараа Монгол Улсын Төрийн дууллыг “Их хуралдай” танхимд эгшиглүүлэхэд хуралдаанд оролцогсод суудлаасаа босож хүндэтгэл үзүүлэв.

Төрийн дуулал эгшиглэж дуусмагц Улсын Их Хурлын дэд дарга Б.Пүрэвдорж Засгийн газрын гишүүн Х.Ганхуягт баяр хүргэв.

*Тангараг өргөх ёслол 19 цаг 37 минутад өндөрлөв.*

*Чуулганы нэгдсэн хуралдаанаар 9 асуудал хэлэлцэв.*

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Чуулганы хуралдааны хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

*Хуралдаан 3 цаг 34 минут үргэлжилж, 126 гишүүнээс 101 гишүүн хүрэлцэн ирж, 80.2 хувийн ирцтэйгээр 19 цаг 38 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**

ЕРӨНХИЙ НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА

Б.БААСАНДОРЖ

**Тэмдэглэл хөтөлсөн:**

ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ  
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр,  
Лхагва гараг Төрийн ордон “Их хуралдай” танхим 14 цаг 06 минут.

### НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

---

**Б.Пүрэвдорж:** Улсын Их Хурлын гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Гишүүдийн ирц 126 гишүүнээс 74 гишүүн ирж 58.7 хувиар ирц бүрдсэн байна. Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы 2025 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээгдсэнийг мэдэгдье ээ.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Өнөөдрийн хуралдаанаар дараах 9 асуудлыг хэлэлцэнэ.

Нэгдүгээрт, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 3 дахь хэлэлцүүлэг, Засгийн газар 2025 оны 9 сарын 1-ний өдөр өргөн мэдүүлсэн, 3 дахь хэлэлцүүлэг.

Хоёрдугаарт, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 4 дэх хэлэлцүүлгийг явуулна, Засгийн газар 2025 оны 9 сарын 1-ний өдөр өргөн мэдүүлсэн, 4 дэх хэлэлцүүлэг,

Гуравдугаарт, Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, ЭМД-ын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн дөрөв, тав дахь хэлэлцүүлгийг явуулна, Засгийн газрын 2025 оны 9 сарын 1-ний өдөр өргөн мэдүүлсэн.

Дөрөвдүгээрт, “Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үргэлжлүүлэн хэлэлцэнэ, Улсын Их Хурлын гишүүн Л.Оюун-Эрдэнэ нарын 33 гишүүн, 2025 оны 10 сарын 6-ны өдөр өргөн мэдүүлсэн үргэлжилнэ.

Тавдугаарт, Монгол Улсын Их Хурлын дэд даргыг огцруулах тухай асуудлыг үргэлжлүүлэн хэлэлцэнэ.

Зургаадугаарт, Монгол Улсын Их Хурлын дэд даргыг сонгох тухай асуудлыг хэлэлцэнэ,

Долоодугаарт, Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Наймдугаарт, Монгол Улсын Засгийн газрын гишүүнийг огцруулах томилох тухай Монгол улсын ерөнхий сайдын танилцуулгыг сонсоно.

Есдүгээрт Засгийн газрын гишүүн Улсын Их Хуралд тангараг өргөнө өө.

Хэлэлцэх асуудалтай холбоотойгоор бүлгээс болон зөвлөлөөс албан бичиг ирээгүй. Хэлэлцэх асуудалдаа оръё оо.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 3 дахь хэлэлцүүлгийг явуулна.

Төслийн 3 дахь хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороодын хамтарсан хуралдааны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Баатаржавын Мөнхсоёл танилцуулна. Индэрт урьж байна.

Хасбаатарын Ганхуяг гишүүн уншина аа.

**Б.Пүрэвдорж:** Улсын Их Хурлын дэд дарга эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 9 дүгээр сарын 1-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 онд төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 онд төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дахь хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2025 оны 11 дүгээр сар 11-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар явуулж 3 дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороодод шилжүүлсэн.

Байнгын хороод 2025 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн хамтарсан хуралдаанаар хуулийн төслийн 3 дахь хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.4-д заасны дагуу явууллаа.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 онд Төсвийн хүрээний мэдэгдэл 2027-2028 онд төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл ДНБ-ий бодит өсөлтийн хэмжээг 2026 онд 5.7 хувь, 2027 онд 6.3 хувь, 2028 онд 6.5 хувь байх, хэрэглээний үнийн өсөлтийн түвшнийг 2026 онд 7 хувь 2027 онд 6 хувь 2028 онд 50 хувь байхаар тооцсон.

Мөн макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн үзүүлэлтүүдтэй уялдуулан нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын доод хэмжээг 2026 онд 31 их наяд 930 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 31.2 хувь, нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ 32 их наяд 980 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 32.2 хувь, нэгдсэн төсвийн суурь тэнцэл 2 их наяд 70 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 2 хувь, Засгийн газрын өрийн хэмжээ 51 их наяд 200 тэрбум төгрөг буюу дотоодын бүтээгдэхүүний 50 хувьтай тэнцэхээр байна аа.

Нэгдсэн хуралдааны 2 дахь хэлэлцүүлгээр олонхын санал дэмжлэг авсан саналыг хуулийн төсөлд нэмж тусган 3 дахь хэлэлцүүлгийг бэлтгэсэн төсөл болон Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороодын хамтарсан хуралдаанаас гаргасан танилцуулгыг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 онд төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 3 дахь хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороодын хамтарсан хуралдаанаас гаргасан танилцуулгыг хэлэлцэж шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсэж байна аа. Баярлалаа.

**Б.Пүрэвдорж:** Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороодын хамтарсан хуралдаанаас гарсан санал, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан төсвийн тусгай шаардлагад нийцсэн эсэх талаарх Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлтийг зөвлөлийн гишүүн Нинжбатын Ууганбаатар танилцуулна. Таныг индэрт урьж байна.

**Н.Ууганбаатар:** Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын чуулганы 2025 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын нэгдсэн төсвийн 26 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар хэлэлцүүлэг явагдаж төслийн 1 дүгээр зүйлийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт дэх нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын доод хэмжээ 2026 онд 31.6 их наяд төгрөг гэснийг 31930 тэрбум төгрөг гэж, ДНБ-д эзлэх хувь 2026 онд 30.9 гэснийг 31.2 гэж, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл -1.3 гэснийг -1.0 50 гэж, ДНБ-д эзлэх хувь 2026 онд -1.3 гэснийг -1.0 гэж, нэгдсэн төсвийн суурь зарлагын дээд хэмжээ 2026 онд 29.552 их наяд гэснийг 29.859.1 тэрбум гэж, дотоодын бүтээгдэхүүнд эзлэх хувь 28.9 гэснийг 29.2 гэж, нэгдсэн төсвийн суурь тэнцэл 2.48 тэрбум төгрөг гэснийг 2.70 тэрбум төгрөг гэж тус тус өөрчлөх гэсэн зарчмын зөрүүтэй санал дэмжигдсэн байна аа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 64.1.5-д нэгдсэн хуралдаанаар 3 дахь хэлэлцүүлэг явуулахад явуулахад Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороодын хамтарсан хурлаас гарсан санал Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан төсвийн тусгай шаардлагад нийцсэн эсэх талаар, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлд дүгнэлт гаргаж нэгдсэн хуралдаанд танилцуулна.

Төсвийн тусгай шаардлага хангагдаагүй нөхцөл үүссэн тохиолдолд тодорхой асуудлаар чиглэл өгч 2 дахь хэлэлцүүлгийг дахин явуулахаар Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороонд төслийг буцааж болно хэмээн заасны дагуу Төсвийн тогтвортой байдлын зөвлөлд дүгнэлт гарган танилцуулж байна аа.

Дээрх өөрчлөлт нь

1.Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1 дүгээр заалт дахь төсвийн тусгай шаардлагуудыг хангасан байна.

2.Төсвийн хүрээ өөрчлөгдсөнтэй холбогдон төсвийн төсөл дээр төсвийн орлого нэмэгдэх мөн төсвийн суурь зарлага нэмэгдэх хөрөнгийн зардал буурах буюу зарлагын бүтцэд өөрчлөлт орох шууд үр дагавартай байгаа нь тоон дүнгээрээ харьцангуй бага хэдий ч чанарын хувьд дунд болон урт хугацаанд эдийн засгийн өсөлт сөргөөр нөлөөлж болзошгүй байна.

3.Монгол Улсын 2026 оны төсвийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төсвийн хүрээний өөрчлөлтийг хэлэлцэж байгаа энэ мөчид төсвийн төслийн 3 дугаар хэлэлцүүлгийн дараа Төсвийн хүрээний мэдэгдлийн 2 дугаар хэлэлцүүлгийг явуулах замаар буюу төсвийн 3 дугаар хэлэлцүүлгийн үр дүнгээр төсвийн хүрээг өөрчилж байгаа нь хүрээнд төсвөө дагадаг буруу жишгийг дахин давтаж байгааг цаашид анхаарах шаардлагатай байна аа.

Төсвийн тогтвортой байдлын зөвлөл.

**Б.Пүрэвдорж:** Ажлын хэсгийн гишүүдийн нэрсийг танилцуулъя.

Ням-Осорын Учрал Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг хөгжлийн сайд, Нинжбатын Ууганбаатар Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Жамсрандоржийн Дэлгэрсайхан Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Равсалын Ренчинбазар Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Жигжидийн Ганбат Сангийн яамны ТНБД, Баярсайханы Баярдаваа Монголбанкны Мөнгөний бодлогын газрын захирал, Сэрээнэндоржийн Төгсжаргал Татварын ерөнхий газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, Лхагвабаярын Энх-Амгалан Эдийн засаг хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Мижиддоржийн Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга, Ганболдын Золбоо Сангийн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын дарга, Жамъяншаравын Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Отгондэмбэрэлийн Мягмардорж Эдийн засаг, хөгжлийн яамны Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга, Цасчихэрийн Мөнхдэлгэр Эдийн засаг, хөгжлийн яамны Эдийн засгийн бодлого төлөвлөлт төсөөллийн хэлтсийн дарга, Рэгзэнгийн Мягмаржав Татварын ерөнхий газрын Татвар хураалтын удирдлага арга зүйн газрын дарга, Төсвийн болон Эдийн засгийн байнгын хорооны хамтарсан хуралдааны танилцуулгатай холбогдуулан асуулт асуух гишүүд нэрээ өгнө үү. Дуламын Бум-Очир гишүүнээр тасаллаа.

Бум-Очир гишүүн асуулт асууя.

**Д.Бум-Очир:** Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Би асуулт асуухгүй үг хэлэх гэж байгаа юм аа. Энэ жилийн төсөв нэлээн хүнд боллоо бид нар бүгдээрээ харж байна. Ард түмнээ болоод гишүүдээ сонсоод анхнаасаа төсвөө аятайхан боогоод ороод ирэхгүй яасан юм бэ гэдгийг би бас хэлмээр байна аа. Улс төрийн үүднээс ч тэр нийгмийн байдлаа харсан ч гэсэн бид нар ингээд ямар байгааг мэдэж байгаа шүү дээ. Намын мөрийн хөтөлбөртөө ч бид нар заачихсан байж байгаа шүү дээ. Тэтгэврийг нь тэр инфляцтай уялдуулна нэмэгдүүлнэ энэ тэр гээд. Тэгээд бөөн юм болж болж арай гэж ямар ч байсан багш, эмч нарынхаа цалинг, тэтгэвэр тэтгэмжээ нэмэхээр боллоо. Уул нь ингэж хүндрүүлэхгүйгээр өөрсдөө шийдээд боломжоороо нэмээд ороод ирэх боломж байсан юм шиг өнөөдөр харагдаж байна шүү дээ. Дараа жил дахиад битгий ингээсэй л гэдгийг хүсмээр байна. Дахин давтагдаад байгаа байхгүй юу. Миний хувьд багш нарын цалингийн тухай асуудлыг яг жилийн өмнөөс ачаалал нь их цалин нь бага байна аа гэдгийг зөндөө ярьж байсан зөндөө багш нар ч гэсэн хэлсэн.

Өнгөрсөн хаврын чуулган дээр Байнгын хороон дээр мөн хэлсэн. Жаахан ч болсон хамаагүй нэмж өгөх шаардлагатай шүү гэдгийг хэлсэн. Тэгээд хамгийн гол нь сонсохгүй байна л даа. Гишүүдээ сонсохгүй, ард иргэдээ сонсохгүй. Тэгээд сүүлдээ үндсэндээ жагсаал цуглаан болоход хүрч байж, ийм байдалд хүрч байж

нэмэх шийдвэр гаргаж байгаа юм. Ямар ч байсан багш, эмч нарын цалин тэтгэврийг нэмж байгаад баяртай байна. Засагт болоод энэ төсөв дээр ажилласан бүх хүмүүст талархаж байгаагаа илэрхийлье. Ямар нэгэн хэмжээнд нэмж байгаад баяртай байна аа, ард иргэд ч гэсэн баяртай байгаа гэж найдаж байна. Багш нар маань ч гэсэн баяртай байгаа гэж найдаж байна. Энийгээ гол нь дараа жилийн төсөв дээрээ дахиж барьж орж ирээрэй л гэдгийг хүсмээр байна аа. Баярлалаа.

**Б.Пүрэвдорж:** Хэн хариулах вэ? Үг хэлсэн. Тэгэхээр Бум-Очир гишүүн ээ ер нь бол Их Хурлын гишүүд энэ цалин тэтгэвэртэй холбоотой асуудлаар хууль санаачилж гаргах бүрэн боломжтой. Өөрөөр хэлбэл өнгөрсөн хугацаанд олон жил зүтгэж санаачилж явсан хүний хувьд энэ тэтгэврийг индексжүүлэх тухай хуулийг буюу энэ жил хэдэн хувийн инфляцтай байна ирэх онд нь тэдэн хувиар тэтгэвэр нэмдэг хуулийг санаачилсан. Урьд нь 8 жилийн туршид хоёрхон удаа тэтгэвэр нэмсэн байхгүй юу даа. Одоо бол жил болгон инфляцтай уялдуулаад нэмэгдүүлэх энэ хууль маань батлагдсаны үр дүнд энэ ахмадын тэтгэвэр жил болгон нэмэгдээд явж байгаа. Тэрэнтэй адилхан та төрийн албан хаагчдын цалинг инфляцтай уялдуулан нэмэх цалинг индексжүүлэх тухай хуулийг өргөн барих юм энэ чинь жил болгон шийдэгдээд явна гэсэн үг. Тэгэхээр ер нь Их Хурлын гишүүд өөрсдөө бас санаачилгатай байх нь зүйтэй гэж бас зөвлөмөөр байна.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 4 дэх хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороо болон Эдийн засгийн байнгын хороонд шилжүүллээ.

Одоо Төсвийн байнгын хороо хуралдаж хуралдана.

15 цагаас чуулганыг дахин хуралдуулъя. Нэгдсэн чуулганыг түр түр завсарлуулъя.

## ЗАВСАРЛАГА

**Б.Пүрэвдорж:** Үдээс хойших хуралдаан үргэлжилж байна.

[Хэлэлцэх асуудалдаа орёе. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 4 дэх хэлэлцүүлгийг явуулна аа.](#)

Төсвийн байнгын хороо болон Эдийн засгийн байнгын хороо, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 4 дэх хэлэлцүүлэгт бэлтгэн гишүүдэд тараасан байна.

Гишүүд санал хураалтад бэлтгэе ээ. Одоо хуулиудыг 64 гишүүнээр буюу олонхын саналаар батлах учраас гишүүдийг чуулганы танхимд орж ирэхийг урьж байна. 2 бүлгийн дарга ирцээ сайжруулъя.

Арван есхөн гишүүн санал хураалтад бэлтгэж хурууны хээ уншуулсан байна. Сайд нар гишүүдээ дууд. Түр завсарлуулаад оруул л даа. Түр хороог түр

завсарлуулъя. Тэнд нэлээн олон гишүүн байх шиг байна. Ирцийн санал нэг хураачихъя тэгэх үү. Ирцийн санал хураалт.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураана аа.

Санал хураалт хийе 93 гишүүнээс 70 гишүүн дэмжиж 75.3 хувиар санал дэмжигдлээ хуулийн төслийг баталлаа.

Улсын Их Хурлын гишүүд, ажлын хэсэгт талархаж байна аа.

15.58 цаг

Хэлэлцэх асуудал 3.

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, ЭМД-ын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн 4 дэх хэлэлцүүлгийг явуулна.

Төслүүдийг 4 дэх хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар Төсвийн байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, Төсвийн байнгын хорооны дарга Хассуурийн Ганхуяг танилцуулна. Индэрт урьж байна.

**Х.Ганхуяг:** Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 9 дүгээр сарын 1-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2026 онд төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 онд төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 онд төсвийн тухай, ЭМД-ын сангийн 2026 онд төсвийн тухай хуулийн төслийн 3 дахь хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2025 оны 11 дүгээр сарын 7-ны 10-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлгийг явуулж 4 дэх хэлэлцүүлэг бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн.

Төсвийн байнгын хороо 2025 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн. Хуралдаанаараа хуулийн төслүүдийн 4 дэх хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын хур чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 72 дугаар зүйлд заасныг баримтлан явууллаа.

Байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, ЭМД-ын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүдийг 3 дахь хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналуудыг төсөлд нэмж тусгалаа. Багш, эмч, эмнэлгийн байгуулагсдын ажиллагсад, Төрийн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн ажиллагсдын цалин, ахмад настны болон халамжийн дэвтрийг инфляцын түвшинтэй уялдуулан нэмэгдүүлэхтэй холбоотойгоор төсвийн ерөнхийлөн захирагчийн урсгал зардлыг 6-аас 12.8 хувиар бууруулах зарим төсвийн ерөнхийлөн захирагчийн урсгал зардлыг 2025 онд түвшинд байлгах, тэвчиж болох зардлуудыг хойшлуулах зэрэг өөрчлөлтүүдийг тусгасан болно.

Монгол Улсын төсвийн төсвийн хөрөнгө оруулалтаас санхүүжих хөрөнгө оруулалтын зарим төслүүдийг хасах, 2026 онд дуусах хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг бууруулахгүй байх зарчмыг баримталсан бөгөөд 2027 он болон дараа онуудад шилжих төслүүдийн санхүүжилтийг тодорхой хувиар бууруулах, улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөтэй уялдаагүй хөрөнгө оруулалтын зарим төслүүдийг хасах, зарим салбарын тоног төхөөрөмжийн зардлыг 50 хувиар бууруулахаар тусгалаа.

Дээрх өөрчлөлтүүдийг төсвийн төсөлд тусгаснаар Монгол Улсын 2026 онд нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлогыг 30 их наяд 930 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 31.2 хувь, нийт зарлагыг 32 их наяд 980 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 32.2 хувь, нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлыг алдагдлыг -1 их наяд 0.50 тэрбум буюу ДНБ-ий хасах нэг хувьтай тэнцүү байхаар тооцлоо.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн 3 дахь хэлэлцүүлгийг хийх үед Улсын Их Хурлын гишүүдээс Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.1 дэх хэсэгт заасны дагуу хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний төсөвт өртөг санхүүжигдэн өөрчлөхгүй, агуулга зарчмыг алдагдуулахгүйгээр арга хэмжээний нэр, хүчин чадал, байршилтай холбоотой залруулга хийх саналыг гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно оо.

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, ЭМД-ын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн эцсийн хувилбарыг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, ЭМД-ын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүдийг 4 дэх хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар Төсвийн байнгын хорооны танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсэж байна аа. Баярлалаа.

Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Болдын Жавхлан Сангийн сайд, Занданбазарын Цэдэнжав Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч, Дэлгэрийн Энхболд Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор, Жигжидийн Ганбат Сангийн яамны ТНБД, Төмрийн Баясгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Төр, хувийн хэвшлийн түншлэлийн газрын дарга, Батболдын Мөнхтөр Эдийн засаг, хөгжлийн яамны Шинжлэх ухаан, технологийн бодлого төлөвлөлтийн газрын дарга, Мижиддоржийн Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Ганболдын Золбоо Сангийн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын дарга, Бямбарагчаагийн Тэлмүүн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Жамьяншаравын Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Солонгын Тулга. Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга, Сэрээнэндоржийн Төгсжаргал Татварын ерөнхий газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, Пүрэвдоржийн Чандмань Эдийн засаг, хөгжлийн яамны Тогтвортой хөгжил, нийгмийн бодлогын хэлтсийн дарга, Жаргалсайханы Гэрэлбат Эдийн засаг, хөгжлийн яамны ТЗУГ-ын Санхүүгийн хэлтсийн дарга, Лувсанвандангийн Ичинноров Сангийн яамны Төсвийн орлогын

хэлтсийн дарга, Пүрэвдоржийн Бат-Эрдэнэ Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн дарга, Рэгзэнгийн Мягмаржав Татварын ерөнхий газрын Татвар хураалтын удирдлага, арга зүйн газрын дарга, Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан тайлбар хийх асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгнө үү?

Пунсалмаа гишүүнээр тасаллаа. Пүрэвжавын Сайнзориг гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

**П.Сайнзориг:** Баярлалаа. Тэгээд одоо өнөөдрийн бас энэ төсөв батлагдахтай зэрэгцээд энэ төлөвлөлтийн асуудлаас эхлээд ярихгүй бол болохгүй байна аа гэдэг зүйлийг л хэлмээр байна зарчмын хувьд. Багш нар ер нь нийгмийн салбарынхан бас энэ цалин цавууны асуудлыг нэлээн л эртнээс ярьж байсан. Энэ асуудлыг яг төсвийг боож боловсруулах явцдаа ч гэсэн харгалзаж үзээд бас тодорхой хэмжээнд бас саналыг нь тусгах талаар ажиллахгүй бол яг энэ төсвийг батлах, хэлэлцэн батлах процесс дээр ирэхээрээ маш их хэмжээний төсөв задрах байдаг юм уу ийм зүйл рүү ингээд явж байна аа. Энэ дээрээ цаашдаа хаа хаанаа бас анхаарах зайлшгүй шаардлага байна аа гэдэг зүйлийг хэлмээр байгаа юм. Нөгөөтээгүүр энэ Төсвийн хууль дээр шинээр хөрөнгө оруулалтууд мөнгө байхгүй гэсэн мөртөө маш олон шинээр хөрөнгө оруулалтуудыг оруулж ирлээ. Энэ хөрөн мэргэжлийн байгууллага нь энэ шинээр хөрөнгө оруулалтад орж ирж байгаа энэ төсөл хөтөлбөрүүд чинь төсвийн хуульд заасан энэ шаардлагыг хангахгүй байна шүү гэдэг зүйлийг л удаа дараа хэлж байгаа. Тэгээд энэ төсөв маань угаасаа 5 сарын 31-ний дотор төсөвт заасан энэ төсөл хөтөлбөрүүдийг тендер худалдан авалтыг нь хийж чадахгүй бол татагддаг.

Яг л нэг ийм хагас жилийн настай хөрөнгө оруулалтын чиглэлийн юмнууд нь явж байна даа. Тэгээд манай АН-ынхныг бас баахан шаардлага хангахгүй төсөл хөтөлбөрийг нь тойргууд дээр нь тавиад л ер нь татах энэ чиглэл рүү нь оруулчхав уу даа. Энэ дүгнэлтээр чинь хэлчихсэн байна лээ шүү дээ. Нийт 111. Одоо 158 болчихоод байгаа. 111-ийн чинь 83 нь л гэхэд хуульд нийцэхгүй байна аа. Ийм л төсвийг өнөөдөр батлах гэж байна. Одоо харамсалтай байна. Санал хураалтууд нь Байнгын хороон дээр болон чуулганы нэгдсэн хуралтай лаазтай явлаа. Эндээс лааз өргөсөн тэндээс гишүүд нь улаан ногоон юм байна шүү гээд л ярилцаад л ингээд л явлаа. Ийм онигоотой байдлаар анх удаа төсвийг баталлаа. Энэ үйл ажиллагааг хийсэн хүн маань өнөөдөр сайд болох гэж байх шиг байна харамсалтай. Ингэж төсвийг татвар төлөгчдийн мөнгийг хулгай хийж ингэж тодорхой эрх ашгуудад зориулж өгчхөөд сайд болдог жишгээ Монгол төр дээр гаргаж ирлээ. Туйлын харамсалтай. Зүгээр л ил тод юмаа тайлагнаад явчхаж чадахгүй, бүх зүйлийг хүч түрсэн. Байнгын хорооны түвшинд гишүүдээс асуулт асуулгагүй. Хариулт авах боломжийг нь шууд хаасан. Ажлын хэсгийн санал дүгнэлтээ танилцуулахгүй явах ч гэдэг юм уу ийм олон зүйлүүд хийлээ.

Би тэгээд эцэст нь энэ татварын реформ энэ тэр бол худлаа болж байгаа юм байна гэдэг зүйлийг хэлье. Энэ НӨАТ-ын буцаан олголтыг 5 хувийг өгнө гэсэн боловч 10 дугаар сарын 1 хүртэл хойшлуулж байгаа юм байна. Тэгээд цаашдаа ер нь төсөв хүндрээд ирэхээр энэ хэрэгжих юм уу үгүй юу сайн мэдэхгүй байна. Ингэж бас аж ахуй эрхэлж байгаа болон энэ жижиг дунд бизнес эрхэлж байгаа хүмүүсүүдийг бас шилний цаанаас мөхөөлдөс долоолгож болохгүй ээ дандаа худлаа хэлж байна. Ийм л зүйлийг хэлмээр байна. Тэгээд эцэст нь бол одоо энэ төлөвлөлтөөсөө эхлээд анхаарахгүй бол болохгүй нь. Энэ төлөвлөлт хариуцаж байгаа Эдийн засгийн хөгжлийн яаманд нь тэр яг энэ төлөвлөлтийн дагуу шийдвэр

гаргах эрхүүдийг нь өгмөөр байна. Хөдөлмөр эрхлэлттэй холбоотой асуудлуудыг өгмөөр байна.

Эргээд энэ төрийн өмчит ААН байгууллагуудын хувьчлах асуудлын шийдвэр гаргалтуудыг өгмөөр байна. Өнөөдөр энэ улсын төсвөөс чинь өндөр бас төсвийг ТӨК-уд захиран зарцуулж байгаа шүү. Энийг бид нар ингээд төсөв хэлэлцэж байхдаа юу ч ярьсангүй. Тэгээд энийг бас тодорхой дорвитой арга хэмжээ авч байж энэ төсвийн орлогыг бүрдүүлэх асуудал дээр анхаарахгүй бол цаашдаа болохгүй болжээ гэдэг зүйлийг бас хэлмээр байна. Тэгээд ирэх жил бас гадаад нөхцөл байдалд таатай байж нүүрс маань их зарагдаасай л гэж эцэст нь хүсэж байна.

Тэгээд өнөөдрийн энэ батлагдсан төсөв нэг хэрэгжээд яваасай. Яах вэ энэ алдаа оноотой зөндөө л юмнууд байна лээ. Сургамжтай ч зүйлүүд байна лээ. Тэгэхдээ зарим зүйлүүдийгээ цаашдаа давтахгүйн тулд бас эргээд.

**Б.Пүрэвдорж:** Үг хэллээ. Даваахүүгийн Пүрэвдаваа гишүүн асуулт асууя.

**Д.Пүрэвдаваа:** Энэ өдрийн мэндийг хүргэе ээ. Үндэсний аудитын газраас асуулт асуумаар байна. Үндэсний аудитын газар би мэдээлэл хүсэх тухай албан тоот явуулсан. Энэ 111 төсөл арга хэмжээ хуульд нийцэж байна уу үгүй юу, хэр судалгаатай юм, ямар нэгэн байдлаар аудитын байгууллагаар хянагдсан уу гэдэг мэдээлэл авахаар хандсан.

Магнайсүрэн даргын гарын үсэгтэй хариу ирсэн. Энэ хариун дээр 28 төсөл арга хэмжээ нь зөрчилтэй байна аа. 66 тэрбум төгрөгийн зөрчилтэй байна аа гээд хариу ирсэн. Ганхуяг дарга аа асуулт байгаа шүү та түр сууж хайрлаач. Тийм учраас аудитаас асуух энэ нэг бодитой хариулт авмаар байна. 66 тэрбум төгрөг гэдэг маань 2026 онд нэмэгдэж байгаа 360 тэрбумыг чинь бараг 20 хувь нь байгаа. Зөрчилтэй гэдгийг аудитын байгууллага нотолчихсон. Ганхуяг ажлын хэсгийн ахлагчаас нэг юм асууя аа. Та хариуцлага үүрэх үү? Даваасүрэн дарга 2012 онд энэ төсвийн зардлыг хувьчилж хасахаар зэрэг эрүүл мэндийн байгууллага тэр жил 5 хүүхэд эндсэн юм аа. 5 хүүхэд эндсэн асуудлыг хэн хариуцах юм бэ гээд сүүлд нь Улсын Их Хурал дээр хариуцах эзэнгүй болж хувирсан юм.

Сангийн яам Засгийн газар бол 9 сарын 1-нд төсвөө боогоод өгчихсөн. 9 сарын 1-ээс хойш зөвхөн Их Хурлын асуудал. Тэгээд энэ Их Хуралд сууж байгаа 126 хүн хариуцлага үүрэхгүй. Таны удирдан зохион байгуулсан ажлын хэсэг энэ зүйл дээр хариуцлага үүрэх үү гэж би бүүр тэмдэглэлд тусгуулж асуумаар байгаа юм. 2026 онд ямар нэгэн асуудал болох юм бол та хариуцлага үүрэх ёстой.

Дараагийн дугаарт та хэлэлцэж байна гээд индэр дээрээс илтгэл тавилаа. Бид нар 3 дугаар хэлэлцүүлгийг хийгээгүй шүү. Санал хураалт л явуулсан. Улсын Их Хурлын индэр дээрээс худлаа хэлнэ гэдэг бол өөрөө хуультай. Энэ дээр хууль дээдлэх зарчмыг баримтална гэж байгаа. Та дөнгөж танилцуулахдаа 3 дугаар хэлэлцүүлгийг гэсэн шүү санал хураалт биш шүү. Та болохоор Улсын Их Хурлын гишүүний эрхэд халдсан, Дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйл дээр бичээстэй байгаа. Хэлэлцэж байгаа асуудлаар асуулт асуух хэрэгтэй. Та хэрэвзээ асуулт асуулгахгүй байсан юм бол тэр хуралдаандаа яах гэж ажлын хэсэг аудит болон энэ Сангийн яамныхныг оруулсан юм? Тэр тайлбараа өгөөч. Тэгээд тодруулъя.

**Б.Пүрэвдорж:** Эхлээд Индрийн 3 дугаар микрофон аудитын орлогч дарга Цэдэнжав.

**3.Цэдэнжав:** Пүрэвдаваа гишүүний асуултад хариулъя аа.

Пүрэвдаваа гишүүнээс Монгол Улсын Ерөнхий аудиторт асуулга тавьсан. Үүний дагуу 2025 оны 11 сарын 10-ны өдөр бид хариуг хүргүүлсэн. Энд 2026 оны төсвийн тухай хууль, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай хууль эдгээрийг дагалдан ирсэн саналын томьёоллын хавсралт 2-т 1 их наяд 149.4 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 363.9 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй, 111 төсөл арга хэмжээний тухай асуулт тавьсан. Эндээс Үндэсний аудитын газрын улсын төсвийн хөрөнгөөр өмнөх онуудад ажил нь хийгдсэн боловч төсөвт өртөг нэмэгдэж байгаа барилга байгууламжийн аудитын дүгнэлт гаргах тухай Төсвийн байнгын хорооны тогтоолын дагуу бид дүгнэлт гаргаж дүгнэлтээ Сангийн яам болон Төсвийн байнгын хороонд хүргэсэн. Аудитад хамрагдсан эдгээрээс 28 төсөл арга хэмжээ байгаа. 14 төсөл арга хэмжээний төсөвт өртгийг нэмэгдүүлэх дүнг тус жагсаалтад 66.8 тэрбум төгрөгөөр зөрөөтэй тусгасан гээд хавсралтыг Их Хурлын гишүүнд хүргүүлсэн байгаа.

**Б.Пүрэвдорж:** Төсвийн байнгын хорооны дарга, ажлын хэсгийн дарга Хассуурийн Ганхуяг хариулна.

Ер нь нэлээн хүнд нөхцөлд төсөв батлагдах хэлэлцэгдэх байдалтайгаар явагдлаа. Нийтдээ зөвхөн цалин, тэтгэвэр, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэтгэлэг шинжлэх ухааны ажиллагсдын цалин. Ингээд нийт нэг 980 гаруй тэрбум төгрөгийн санхүүжилт шаардлагатай болсон. Үүнийг гаргахын тулд бид нар урсгал зардал дээрээс ч гэсэн тодорхой хэмжээний зохицуулалтын саналууд орж ирсэн. Мөн зардал тал дээрээ эх үүсвэр бий болгох асуудал ч орж ирсэн. Тэрийг нь би гадаадын зээл ашиглалтын зарлагын хэмжээ, мөн НӨАТ-ын орлого тал дээрээ бид нар эх үүсвэрээ НӨАТ-ын татвартай холбоотой асуудлуудыг хойшлох байдлаар бид эх үүсвэр дээр гаргасан байгаа. Урсгал зардлаасаа жигд 12.8 хувийг суутгаж байгаа. Гэхдээ эдийн засаг боловсрол болон эрүүл мэнд, хүүхдийн мөнгө болон төрийн албан хаагчдын цалин гэх мэт нэлээн онцгой байдалд холбоотой зардлууд.

**Б.Пүрэвдорж:** Нэмж нэг минутаар тодруулж хариулъя.

Хариуцлага үүрүүлэх та сонирхолтой байх шиг байна аа. Гэхдээ энэ бол хамтын шийдвэр гэсэн үг. Бид нар бол яам болгонтой нь хамгийн багадаа 3-аас 5 удаа уулзалт хийж хөрөнгө оруулалтын асуудлууд дээр алийг нь танаж болохоор байна, урсгал зардал дээр нь бид нар алийг нь танаж болохоор байна? Хамгийн галтай гэсэн салбаруудаа бид нар энэ урсгал зардлын таналт руу ерөөсөө оруулаагүй, оруулаагүй. Энэ бол би дахиад хэлье. Эрүүл мэндийн салбар, боловсролын салбар, Онцгой байдал гээд гол гол салбаруудаас бид нар нэг ч төгрөг танаагүй. Урсгал зардлаас нь. Хөрөнгө оруулалтыг ч танах юу танахгүй байхаар хийгдсэн. Аудиттай холбоотой бас асуултыг асуух шиг боллоо. Аудит дээр бол юу байгаад байгаа юм. Нөгөө зураг төсөв ТЭЗҮ гэсэн нэг хэдэн төслүүд байсан. Тэр нь болохоор хамгийн том дүн эзэлж байгаа нь болохоор НҮБ-ын бүтээн байгуулалтын ажил байгаа.

Тэр нь энд 2026 онд болох Копын хуралтай холбоотой бүтээн байгуулалтын ажил байгаа.

**Б.Пүрэвдорж:** Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн асуулт асууна. Уучлаарай Даваахүүгийн Пүрэвдаваа гишүүн нэмж тодруулъя.

**Д.Пүрэвдаваа:** Энэ сайд болох гэж байгаа ажлын хэсгийн дарга маань хариулсангүй ээ би тэмдэглэл тусгаж байгаад хэлье. Хариуцлагын асуудал хууль дээр аягүй сайн тодорхой заачихсан байгаа. Хууль дээдлэх зарчим бид нар баримталж ажиллах ёстой, аудит, Аудитын тухай хууль дээр аудитын дүгнэлтийг заавал анхаарч үзнэ ээ гээд хуульчилчихсан. Ажлын хэсгийн дарга энийг анхаарч үзээгүй. Бүүр хэлэлцэх асуудалдаа ч ороогүй. Асуулт асуух эрхийг хаасан. Энэ бүүр ноцтой бүдүүлэг хуулийн зөрчил шүү Ганхуяг дарга аа. Цаашдаа Байнгын хороон дээр асуулт асуух, мэдээлэл авах, мэргэжлийн байгууллагын дүгнэлт авах эрхийг хааж болохгүй.

**Б.Пүрэвдорж:** Та үг хэллээ. Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн асуулт асууна.

**С.Эрдэнэболд:** Одоогоос 180-аад хоногийн өмнө аудитын дарга Магнайсүрэн даргыг томилогдоход нь бүүр онцгойлж хэлсэн зүйл бол энэ Монгол Улсын төсөв, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд нийцэж байгаа эсэх талаар 15 жил ёс төдий дүгнэлт гаргасан. Энэ дээр нарийвчилсан зохицуулалт шалгуур үзүүлэлтийг нь тодорхой болгох дээр ажил хиймээр байна аа гэж хэлж байсан. За гэсэн. Дараа нь 8 сарын 28-ны өдөр асуулга явуулсан. Энэ дээр ерөөсөө ингээд шийдвэр гарахгүй байгаад байгаа юм.

Тэгэхээр энэ Монгол Улсын төсвийн эрэмбийг зөв томъёолох Монгол хүний амьд явах эрүүл аюулгүй орчинд амьдрах эрх цаашлаад Монгол Улсын хөгжил дэвшилтэй холбоотой асуудал дээр төсөв сэтгэлийн хөдлөлд автсан улс төржсөн байж болохгүй байх. Түүнийг нь хангах гол зүйл энэ шалгуур үзүүлэлт юм байгаа юм. Тэгээд энэ ажил ер нь яагаад явагдсан уу энэ төсөв дээр хийгдсэн үү гэдгийг хариулмаар байна нэг.

Хоёрдугаарт ажлын хэсгийн даргаас Төсвийн байнгын хорооны даргаас асуухад энэ урсгал зардлыг 6-аас 12.8 хувиар бууруулаад тэгээд энэ тоног төхөөрөмжийн зардлыг 50 хувиар бууруулаад гээд ингэхдээ бол багш, эмч, эмнэлгийн байгууллагын ажиллагсад, төрийн өмчийн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн ажилчдын цалин ахмад настны болон халамжийн тэтгэврийг инфляцын түвшинтэй уялдуулан нэмэхтэй холбоотой асуудал байгаа юм. Тэгэхээр одоо ер нь ингээд онцгойгийнхон ч гэдэг юм уу ер нь ингээд бусад албан хаагч нар бас л тэгээд л дотроо бодож байгаа шүү дээ. Ажил хаяж байж л энэ асуудал явах юм байна аа гэж.

Тэгэхээр энэ асуудал дээр засаг заавал нэг нэг ийм гал унтраах маягаар түр зуур биш ер нь энэ урт хугацаандаа энийг яаж зөв Монгол Улсын өрсөлдөх чадварыг ахиулсан байдлаар шийдэх юм бэ? Нэг.

Хоёрдугаарт, нөгөө нэг олон Учрал сайдын яриад байдаг ТӨК одоо ач холбогдолгүй, үр ашиггүй ажиллаад байгаа, татаас аваад ажиллаад байгаа зүйлүүдийг цомхотгоно. Тэдгээрийн ажилчдын цалинг нь болохоор 3 дахин бууруулна эд нар гэдэг юм чинь явж байгаа юм уу. Ер нь бол бид ингээд төсөв ярихдаа дараа, жилийн төсвийн хүрээ, тэрний дараа жил рүү шилжих төсвийн төсөөлөл ярихдаа энийг тийм судалгаатай сэтгэл хөдлөлөөс ангид шийдмээр

байгаа юм аа. Тэгэхгүй болохоор нэг ийм дуулиан шуугиан болж байж. Тэгээд олон нийтийн санаа бодолд тохируулах байдлаар энэ асуудлыг авч үзэх нь бол Монгол Улсын хөгжилд их тийм оновчтой зүйл биш. Дараа нь Учрал сайдаас асуумаар байгаа юм. 5 жилийн хөгжлийн хөтөлбөр гээд гараад ирсэн. Тэгэнгүүт одоо энэ 5 жилийн хөгжлийн төлөвлөгөөтэй маань энэ бид нарын хэлэлцэж байгаа асуудал 90 нь хэр уялдаж байгаа юм? Дахиад л 5 жилийн туршид бид нар ингээд гал унтраах маягаар явмааргүй байгаа байхгүй юу. Хүйтэн логигоор судалгаан дээр суурилсан байдлаар тэгээд энэ дэлхий нийтийн эдийн засаг бүс нутгийн нөхцөл байдлын асуудал дээрээс нь энэ Монгол Улсад гол валют авчирч байгаа стратегийн бүтээгдэхүүнүүд түүний үнийн хэлбэлзэл. Ингээд Монгол Улсын өрсөлдөх чадвар тэвчиж болох зардлаа хамгийн бага түвшинд нь тэвчээд тэгээд нийгэмд үр өгөөж авчрах энэ боловсрол эрүүл мэндийн салбараа яаж зөв үе шаттайгаар, хатуу болон зөөлөн дэд бүтцийг нь ахиулж хүчитгэх юм бэ гэдэг дээр энэ төсөв чинь урт хугацаандаа бодлогын зөв шийдэл олсон юм уу? Харин Учрал сайд энэ дээр хариулмаар байна. Байхгүй бол Сангийн сайд энэ дээр нь хариулах байх гэж бодож байна. 40 секунд үлдэж байгаа.

Би энд нэг зүйлийг хэлмээр санагдаад байна. Сайнзориг гишүүн Улсын Их Хурлын нэр бүхий гишүүн удаа дараалж муу л бол баруун хойд талын хар овоохой гэдэг шиг энэ Ардчилсан нам руу асуудлыг нялзаах юм аа. Монгол Улсын иргэн хүн Үндсэн хуулиараа шашин шүтлэг, нас хүйс, арьс өнгө, мэдлэг боловсрол, нийгмийн гарал угсаа үл харгалзаж байгаад суугаа газар орондоо эх орондоо эзэн байж төрийн бодлогын үр шимийг хүртэж байх ёстой. Гэтэл сүүлдээ АН-ын гишүүдийн төсөв байдлаар олон удаа яриад иргэдэд буруу зөрүү төөрөгдөл үүсгэж байгаа юм.

Ийм хариуцлагагүй зүйлийг төрийн өндөр албан тушаалтан хэлж болохгүй гэдгийг сана.

**Б.Пүрэвдорж:** Хассуурийн Ганхуяг гишүүн асуултад хариулъя.

**Х.Ганхуяг:** Надтай холбоотойгоор цалин, тэтгэврийн асуудлыг асуучих шиг боллоо гэж ойлгосон. Тэгээд яах вэ? Энэ ер нь бид нар энэ төрийн албан хаагчдын цалингийн энэ бүтэц, тогтолцоо, энэ урамшууллын систем нь яг тэр 1 нэгдсэн 1 хуулиар явахгүй бол салбар болон тусдаа хууль яваад энэ жил одоо яг энэ боловсролын салбар дээр яг ямар асуудал үүссэн бэ гэхээр үндсэн цалин нь 30 хувь, гүйцэтгэлийн нэмэгдлүүд нь 70 хувь байгаа байхгүй юу. Тэгэнгүүт залуу багш нар нөгөө 30 хувийн тэр үндсэн цалин нь буюу аягүй маш бага хэмжээтэй цалин аваад эхэлсэн тэрнээс асуу. Тэрнээс үүдээд л энэ асуудлууд үүсэж эхэлсэн байхгүй юу.

Тэгэхээр бид нар уг нь энэ цалинтай холбоотой асуудал байна. Тэтгэвэртэй холбоотой асуудлууд. Энийг бид нар хаврын чуулганаар эрх зүйн орчныг нь сайжруулахаар хаврын чуулгандаа хийгээд тэгээд жилийн төлөвлөгөөгөө батлаад үүнтэй уялдаж уг нь 9 сарын 1-нд төсөв орж ирмээр байгаа юм. Сая бол одоо нөгөө хаврын чуулганаар бид нар энэ эрх зүйн орчинтой холбоотой асуудлуудаа шийдэж чадахгүй байсаар байгаад л ингээд л салбар салбар дээр гал гараад явчхаж байгаа юм. Тэгэхээр одоо бол бид нар энэ төсвөө баталсных нь дараа ирэх жилийн хаврын чуулганаар энэ саяын яригдаж байгаа энэ цалин тэтгэвэртэй холбоотой асуудлуудыг эрх зүйн орчныг нь шинэтгэх л хийх ёстой юм. Тэгээд яг салбарын хувьд гал хамгаалагч онцгой байдлынхан яаж цалинжих вэ, ямар нэмэгдэл авах вэ? Багш нарын цалинг бол тэр гүйцэтгэлийн үнэлгээг нь 30 хувьд нь авчрах үндсэн

цалинг нь 70 хувь дээр авчрах гээд энэ шинэтгэлүүдээ бид нар энэ хаврын чуулганы хугацаандаа хийж байж тэрийгээ жилийн төлөвлөгөөтэйгөө уялдуулаад тэгээд төсөвтөө уяхгүй болохгүй байх, 1 дүгээр асуудал.

Хоёрдугаар асуудал яг энэ төсвийн хууль болон төсвийн дэгийн хууль дээр 2 том асуудал үүсчхээд байгаа юм. Ямар асуудал үүсэж байна аа гэхээр хуулийн зөрчилтэй санал хураалт хийгдэж тэрэн дээр нь ингээд төсөв тавиад санал хураачихдаг. Тэгээд тэрийг чинь нөгөө яг жишээлбэл бид нар төсөв батлаад явчихвал хэрэгжүүлэхэд маш хүндрэлтэй асуудал үүснэ, 1 дүгээр асуулт.

Тэгэхээр хуулийн зөрчилтэй асуудал дээр санал хураалт хийхгүй байх энэ эрхийг нь хуралдаан даргалагчид өгөхгүй бол бусад хууль дээр болдог юм мөртөө зөвхөн Төсвийн хууль дээр тийм боломж нь байдаггүй. Дэгийн хууль дээрээ мөн ялгаа байхгүй. Байнгын хороон дээр дэмжигдээгүй саналыг чуулган дээр босгох тэр босгыг нь өндөр болгож өгөхгүй бол зарим нэг саналууд үндсэндээ Монгол улсын эдийн засгийг сүйрүүлэхээр хэмжээний саналууд хураагдсан шүү дээ. Тэр өнөөдөр бодитоор л ярихгүй бол болохгүй. Тэгээд тэрийг нь ингээд хураалгаад л асуудлыг нь шийдэхээр лааз ярьдаг, хулгайч гэж дууддаг. Үгүй ээ ингээд та нар бид нар бүгдээрээ л гэрч шүү дээ. Энэ чуулганы танхимд сууж байгаа бүх л гишүүд энийг гэрчлээд сууж байна.

**Б.Пүрэвдорж:** Сүхбаатар Эрдэнэболд гишүүн нэмж тодруулъя.

**С.Эрдэнэболд:** Хассуурийн Ганхуяг гишүүн ээ лааз ярьсан ч байтугай поошки ярьсан ч байтугай ёонкс ярьсан ч байтугай бид нар эмзэглэж болохгүй ажил хийж байгаа. Зүгээр танд нэг өгөх санал гэх юм уу зөвлөгөө байгаад байгаа нь миний саяын хэлсэн яриан дотор нэг чухал юм байгаад байгаа юм аа. Өөрөөр хэлбэл энэ төсвийн эрэмбийг тогтоохдоо тэр үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал гэдэг зүйл чинь зөвхөн Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, батлан хамгаалах бодлого бас биш байхгүй юу. Энэ бол нөгөө хүн төвтэй байх, Монгол Улсын иргэн хүн эрүүл аюулгүй орчинд амьд явах эрхээ баталгаатай эдлэх бөгөөд түүнийх нь баталгааг төр хангах гэсэн зохицуулалт байгаад байгаа юм.

Тийм учраас одоо бид нар ингээд нэг төсөв ярихаар ямар нэгэн өнгө ярьдаг биш, яг тэр эрэмбэ ярьдаг байхад энэ маш чухал байгаад байгаа юм аа. Тэр утгаараа бол энэ жил амжсангүй. Тэр утгаараа бол дараа жил бас энэ асуудал дээр гарахад энэ үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд уялдуулсан энэ хэмжих үзүүлэлт буюу шалгуур үзүүлэлтийг гаргаарай гэж хэлмээр байгаа юм. Тэгж чадах юм бол олон хэрүүл, олон намчирхал, улс төржилт хаагдах боломжтой байна аа гэдгийг тэмдэглэж.

**Б.Пүрэвдорж:** Цагаанхүүгийн Мөнхбат гишүүн асуулт асууна.

**Ц.Мөнхбат:** Өнөөдөр бид нар төсвөө батлах нь ээ. Тэгээд энэн дээр бас нэг ганц нэг ярихгүй бол болохгүй нэг асуудлууд байна. Ажлын хэсгийн даргаас л асууя.

Бид нар бол энэ цалин тэтгэврийг нэмэх ёстой гэдэг дээр ялангуяа манай АН-ын бүлэг бол санал нэгтэй байсан. Тодорхой жагсаал цуглаан эсэргүүцэл тэмцэл болж байж боловсролын салбарыг нэг арай ахиу, эрүүл мэндийн салбар нь арай бага, тэтгэвэр, тэтгэмжийг бас нэг жоохон хөдөлгөсөн маягтайгаар ингээд нэмлээ. Ингэхдээ бид нар энэ хөрөнгө оруулалтууд руугаа л орлоо л доо. Тэгээд би нэг ийм

юм асуух гэсэн юм. Яах вэ энэ удаа энэ зам тээврийн салбарын хөрөнгө оруулалт нэлээн танагдлаа. Хамгийн их хэлмэгдэж байгаа нь манай говиос сонгогдсон ганц сайд бол Дэлгэрсайхан сайд л нэлээн төсвөө тануулчихлаа. 20 хүртэлх тэрбум төгрөгийн өртөгтэй санхүүжилтийг 17.2 хувиар, 20-оос дээш тэрбум төгрөгийн өртөгтэйг нь 28.1 хувиар ингээд танаж байгаа.

Бусад салбараас 15 хувиар танаж байгаа юм. Тэгсэн чинь энэ манай Дундговь аймагт нэг ийм олон жил гацсан нэг ийм төсөл байдаг юм аа. Төв халхын дуулалт жүжгийн театрын барилга гээд 2011 оноос эхлээд явсан. Тэгээд Сангийн Сангийн сайдтай Жавхлан сайдтай миний бие бараг бүтэн жил энэний хойноос ярьж хэлж явж байж энэ жилдээ 10 тэрбум төгрөг тавьяаа гээд ингээд орж ирсэн юм. Яг орж ирэхдээ бол 8.6-аар орж ирсэн. Тэгэхдээ яах вэ 2027, 2028 онд ингээд дуусгачихъя гээд ингэж орж ирсэн ийм төсөл. Тэгсэн 8.6-аас манай Дундговь аймгийн Луус сумын нэг спорт заал 500 сая төгрөг дутчихаад 2-ын хооронд бас нэг олон жил үргэлжилсэн ийм төсөл болох гээд салбар дотор нь зохицуулалт хийе гээд 8.6-аас 500 саяыг нь тийш нь шилжүүлээд 8.1 болгоод явж байсан. Өчигдөр ажлын хэсэг дээр Төсвийн байнгын хороон дээр орохдоо 3.7 болоод ороод ирэх юм.

Бүх салбаруудаас 15 хувь бууруулчихаад яагаад эндээс 60 хувийг нь бууруулчихав аа. Энэ дээр нэг маш тодорхой тайлбар өгөөч ээ ажлын хэсгийн дарга.

Хоёрдугаарт нь ер нь энд бид нар яриад байгаа. Энэ олон жил үргэлжлээд байгаа төсвүүдийг богино хугацаанд дуусгадаг байяаа. Ингэхгүй бол бид нар нөгөө төсөв чинь ингээд жил удаашрах тусмаа л төсөв нэмэгддэг магадлалаар оруулдаг. Одоо бүүр сүүлдээ аудитаар нэмж ордог боллоо. Ер нь бол энэ аудитаар оруулах ер нь зөв юм уу? Тэгвэл шууд аудитаар ордгоо боливол яадаг юм? Ингээд шат шаттай ингээд нэг олон процесс яваад байхаар тухайн жилдээ төсөв нь батлагдахгүй байх нөгөө хэлэлцэж эхлэхэд төсвийн төсөлд нь тусахгүй байх ийм нөхцөлүүд нь улам бүүр бий болоод байгаа байхгүй юу. Энэ зүйлүүдийг болих хэрэгтэй байгаа юм. Энэ аль болохоор энэ процессын юмнуудыг багасгамаар байгаа юм уг нь. Энэн дээр нэг тодорхой тайлбар аваад тэгээд нэг нэмж тодруулъя даа.

**Б.Пүрэвдорж:** Хассуурийн Ганхуяг гишүүн хариулъя.

**Х.Ганхуяг:** Үндсэндээ бид нар энэ их хэмжээний бараг нэг их наяд гаруй төгрөгийн таналт хийгдээд энэ цалин тэтгэвэр рүү зориулахаар яалт ч үгүй нөгөө хамгийн том хөрөнгө оруулалтын орон зай эзэлж байгаа нь авто замынх. Одоо 30 хувь нь яг авто зам дээр байдаг.

Тийм учраас 2026 онд дуусах төслүүдээс нэгийг нь ч хөндөхгүйгээр нэг ёсондоо 2026 онд дуусах нь ирэх жилдээ дуусаж байг ээ. Харин 2027, 2028 онд байгаа замуудаасаа хувьчилж хасаж байгаа. 20 тэрбум хүртэлх нь болохоор 17 хувь, 20 тэрбумаас дээшхийг нь 27, 28 хувиар хасаж байгаа. Хасаад энэ чинь зөвхөн ирэх жил санхүүжих дүнгээс нь л хасаж байгаа гэсэн үг. Тэгээд тэрийг нь 2027 онд дуусах юм бол 2027 онд нь санхүүжилтийг нь бүтэн тавиад дуусгачихъяаа гэдэг зарчмыг барьсан байгаа.

Дундговийн төсөл дээр бол нэг асуудал үүссэн юм нь юу вэ гэхээр яг хуучин суурин дээр барьж болохгүй гэсэн нэг асуудал 1 дүгээрт үүссэн байна лээ.

Хоёрдугаар асуудал болохоор анх 10.3 тэрбумтай байсан төсөл магадлан хийгдээд 38 тэрбум болсон. Үргэлжилж байгаа төсөл хэдий ч ирэх жил заавал ч үгүй тендер зарлаж байж тэр ажил үргэлжилж явах ёстой болчихсон байна лээ.

Тэгэхээр юу гэж дүгнэж байгаа вэ гэхээр бид нар энэ дараа жилийн хувьд одоо тендер нь зарлагдаад ингээд явлаа гэж бодоход газрын асуудал нь шийдэгдээгүй. Тэгээд дараад нь тендер нь амжилттай болох эсэх нь тодорхойгүй.

Гуравт нь салбарын яамнаас нь мэдээлэл аваад яах вэ ирэх жил бид нар ямар ч байсан тендерээ л зарлаад ажлыг нь л эхлүүлэх юун дээр нь онцгой анхаарал тавьяаа. Тийм учраас эндээс татахад бол эргээд нөгөө татгалзах зүйл байхгүй ээ гэдэг л мэдээлэл өгсөн байгаа.

**Б.Пүрэвдорж:** Мөнхбат гишүүн нэмж тодруулъя.

**Ц.Мөнхбат:** Энэ төслийг бол би хамгийн сайн мэдэх төсөл байгаа юм л даа. Тэгээд дахин дахин асуугаад байгаа юм. Энэ 2011 онд л 2 тэрбум төгрөгөөр эхлээд тэгээд 1 суурь болчихоод нэг компани хариуцлагагүй ААН-ээс болоод өнөөдрийг хүрчихсэн. Бид нар Соёлын яамтай, Номин сайдыг байх үеэс ярьж байж Дундговь аймаг руу нь эрхийг нь шилжүүлсэн. Барилгын хөгжлийн төвөөс очиж ажлын хэсэг гарч очоод тухайн суурь өөрөө бэхжүүлээд ашиглаад явахад боломжтой юм байна гэсэн тийм дүгнэлт гарсан. Ийм л төсөл. Тэгээд Дундговь нутаг бас дуу хуур, өв соёлын өлгий нутаг гэж ингэдгийн хувьд энэ зайлшгүй явах ёстой л ийм төсөл байгаа юм л даа. Тэгээд салбарын сайд нь энэ төслийг 15 хувиар биш арай ахиу хасаж болно оо гэсэн ийм хэлсэн гээд байгаа юм. Тэр яг үнэн юм уу? Би уг нь Номин сайдыг байвал өөрөөс нь асуучихмаар байгаа юм. Тэгээд ингэж нөгөө ялгаатай юманд хандаад байхаар л.

**Б.Пүрэвдорж:** Үг хэллээ. Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн асуулт асууна.

**С.Эрдэнэбат:** 2026 оны Монгол Улсын төсөв нийт иргэд ААНБ ямар нөлөөтэй вэ гэдэг талаар хүн болгон бас харж байгаа. Тэгээд ямар ч байсан ирэх жил боловсролын жил гээд онцолж тавьсных хүлээлт их өндөр байсан 1 дүгээрт.

Хоёрдугаарт, ер нь нэг боловсролын салбар маань улсын дундаж цалингаасаа нэлээн доошоо уначихсан орхигдчихсон ийм салбар байсны хувьд бол цалин хөлс орлогыг нь тодорхой хэмжээгээр нэмэгдүүлэх хувийг нь сонсоход нэлээн өндөр сонсоод байгаа боловчиг мөнгөн дүнгээр нь аваад үзэхэд бас тийм айхтар пүү паа гэтэл нэмчихсэн асуудал бол бас биш. Гэхдээ бас өмнөх өмнөх жилүүдийг бодвол нэлээн боломжийн хэмжээгээр би бас нэлээн асуудал болж тохиров уу гэж бодож байна. Гэхдээ тодруулж асуух зүйл байна аа. Ирэх жилийн тавьсан төсвийн юу чинь энэ яг энэ хамтын гэрээ хэлэлцээрийнхээ итгэлцлийн энэ гэрээнийхээ юуг бүрэн хангана биз дээ. Дутаж байгаа эх үүсвэрүүдээ яаж шийдэх вэ гэдэг тал дээр тодорхой бас тодруулж асуумаар байна. Мөн эрүүл мэндийн салбар бас гадаа жагсаал цуглаан ажил хаялт хүртэл ингээд ийм асуудалтай болж байгаа. Яах аргагүй 2 суурь салбар, ооны эвэр шиг 2 салбар учраас ийм асуудалд хандаж байгаа байх аа.

Тэгэхээр энэ эрүүл мэндийн сайд ч гэсэн бас тодорхой даатгалынхаа сангаасаа гэж байна. Бусад янз бүрийн тэр авлага, банкнуудаас авах авлага гээд л бүх л юмыгаа харж байх шиг байна. Тэгэхээр энийг нь биелүүлэх тал дээр манай

Засгийн газар маань дэмжиж өгөөрэй. Тэгэхгүй бол төсөв батлахтай зэрэгцээд ерөнхийд нь шийдчихлээ гээд ажил хэрэг болгохгүй бол энэ эргээд маш том асуудал дагуулна аа гэдгийг бас хэлмээр байна.

Гуравдугаарх нь цалинг индексжүүлэх хуулийг хийнэ ээ гэж Пүрэвдорж дарга бас сая хэлж байсан. Энэ талаар бас ингээд ажиллаад эхэлж байгаа ер нь бид нар ингэж энийг шийдчих хэрэгтэй юм шиг байгаа юм. Тэгэхгүй бол сая яагаад боловсрол, эрүүл мэнд энэ тэр гээд гэнэт одоо ингээд огцом ингээд шаардаад 3 сая гэж ярив гэхээр хамтын 3 талт хэлэлцээрээр жилд нэг 25-аас 30 орчим хувиар нэмээд тэгээд 1 улсын дунджаасаа дээшээ болно оо гэдэг хэлэлцээрийг хийсэн байсан тэр нь хэрэгжихгүй болоод 6 хувиар нэг нэмээд ирэх жил бүр байхгүй. Тэрний дараа жил энэ төсвийн зарлага 24 хувиас хэтэрчихнэ гээд ингээд нэмэх найдвар алга гэдэг итгэл алдарсан учраас энэ хүмүүс чинь ингэж тэмцэж жагсаад байгаа юм шүү.

Зарим хүмүүс нэг Эрдэнэбат энэ ордон дотор суучхаад ордноос удирдаад жагсаагаад ажил хаялт хийлгээд байна гэдэг байдлаар хардаж сэрдээд байх шиг байна лээ. Тэгэх бол шаардлагагүй. Үйлдвэрчний эвлэлийн байгууллага бол 1, 2 хүний дохиогоор явдаг ч тийм байгууллага бол бас биш. Тийм учраас энийг бас бид нар хараад 2028 он гэхэд ер нь Монголчууд ер нь ямархуу цалинтай байх вэ? Хувийн хэвшлийн салбарууд ч гэсэн бид нар тэр цалин хөлс орлогоо нэмэгдүүлэхэд нь тодорхой хэмжээний эдийн засаг төсөв ийм бодлогоор дэмжих ёстой. Тийм учраас энэ тал дээр их зөв ойлголттой байх хэрэгтэй байна. Ингээд цалин нэмэнгүүт үнэ өснө өө гээд эхнээсээ авхуулаад хөөргөөд эхэлчихнэ гээд үгүй ээ. Энэ чинь сая 300 мянган хүний үндсэндээ 100 орчим мянга хүрэхгүй хүний л цалин хөлсний асуудал яригдаж байгаа. Зарим нэмэгдлүүд нь нэлээн бүүр оны сүүл рүү гэдэг байдлаар тавигдсан. Тэгэхээр энэ нийгэмд бас харж байгаа байх буруу зөрүү ойлголтоор бас энийг далимдуулаад багш нарын цалин нэмэгдчихээр бүх юмны үнэ нэмэгдэнэ гэдэг ч юм уу нэг ийм байдлаар бас яриад байгаад нь би бас энийгээ залруулж хэлээрэй. Энэ эдийн засагч санхүүгийнхэн маань.

Ахмадын тэтгэвэр дээр бол яах вэ би холимог хэлбэрээр гээд санал хураалгасан. Харамсалтай нь олонхоор дэмжигдээгүй. Тэгэхээр Засгийн газар маань нэмэхдээ байгаа эх үүсвэртээ тааруулаад бас хэт нөгөө тэтгэврийн зөрөө ялгаатай байгаа учраас энэ дунджийг нь олоод болж өгвөл нэг ойр ойрхон холимог хэлбэрээр ч юм уу мөнгөн дүнгээр ч гэдэг юм уу ийм юмаа бас бодож үзээрэй. Хуулиараа үндэсний зөвлөлийн саналаар Засгийн газар шийдэх ёстой байгаа гэдгийг хэлмээр байна аа.

Тэгээд асуултдаа хариу авъя.

**Б.Пүрэвдорж:** Үг хэллээ. Ганзоригийн Лувсанжамц гишүүн. Наранбаяр сайд хариулъя.

**П.Наранбаяр:** Асуултад хариулъя. Эрдэнэбат гишүүний асуултад.

Тэгэхээр энэ жилийн бид бас энэ үйлдвэрчний эвлэлтэй хамтын хэлэлцээрийнхээ нэмэлт хэлэлцээрийг байгуулж багш нарын үндсэн цалинг 2 сая 226 мянгад хүргэх 1 сарын 1-ээс. 11 сараас 2.8 саяд үндсэн цалинг хүргэх ийм хэлцлийн үр дүнд хүрсэн. Энэ хүрээндээ өнөөдрийн төсвийн энэ санал дотор нэмэлтээр 520 тэрбум төгрөгийн энэ дээр эрдэм шинжилгээний ажилтнуудын бас

цалин нэмэгдэж орж ирсэн. Ингээд ийм хэмжээний нэмэлт нь орчихсон байгаа. Цаашдаа энэ ажилтнуудын асуудал бас бий. Энэ асуудлуудыг бас ярилцаж цаашид нэмэхэд бас 440 орчим тэрбум, 20 орчим тэрбум төгрөг дахиж нэмэлтээр шаардлагатай байгаа. Энэ асуудлыг бид бас энэ хэрвээ цаашдаа төсөв өөрөө тодотгох шаардлага гарвал шийдээд явах боломжтой гэж ингэж бодож байгаа.

Ер нь бол энэ хэлэлцээрээрээ бид бас энэ цалингийн бүтцийг шинэчлэх цаашдаа үндсэн буюу суурь цалинг дээшлүүлэх, нэмэгдүүлэх ийм орон зайг бий болгох ийм шаардлагатай байгааг 2 тал хоёулаа энэ дээр хамтран ажиллахаар тохиролцсон ийм байгаа. Мөн боловсролын салбар дахь өнөөгийн багш ажилтны бүтцийн асуудлыг ч гэсэн авч үзэж цаашдаа илүү оновчтой болгох ажлын байрыг хадгалж бүтээмжийг нэмэгдүүлэх ийм боломжийг хайх ийм шаардлагатай байгааг онцлон тэмдэглэх хэрэгтэй гэж бодож байна. Энэ тал дээр бас энэ ажлын хэсгээс энэ удаад бас Монгол Улсын эдийн засгийнхаа өнөөгийн нөхцөл байдал бусад төсвүүдээс гаргаж авсан санхүүгийн эх үүсвэртээ тааруулж ийм байдлаар бас эхний ээлжид шийдсэн байгаа гэж бодож байгаа. Баярлалаа.

**Б.Пүрэвдорж:** Ганзоригийн Лувсанжамц гишүүн асуулт асууна.

**Г.Лувсанжамц:** Оройн мэнд хүргэе ээ. Энэ төсвийн хууль дээрээ нийтдээ 1 дүгээр хавсралтад 397 шалгуур үзүүлэлт байгаа. Манай 185 дугаар тогтоолоор байгуулагдсан ажлын хэсэгт орж ажилласан нийт энэ гишүүддээ баярлалаа гэж хэлмээр байна. Энэ 397-ийн 225-ыг нь засах сайжруулах тийм саналыг тусгасан. Нэгдсэн чуулганаар та бүхэн дэмжиж өгсөнд маш их баярлалаа. Тэгээд үүнтэйгээ холбоотойгоор зарчим яримаар байна.

Төсвийн хуулийг Засгийн газраас өргөн барихдаа Их Хурал дээр хэлэлцэхдээ хуульд нийцүүлж үр дүнд чиглэсэн байдлаар ажиллах хэрэгтэй байна. Энийг бүүр анхааруулж хэлмээр байна. Өргөн барьсан төсвийн төсөл дээр жилийн хөгжлийн төлөвлөгөөтэй уялдаагүй 77 тэрбум төгрөг, зураг төсөл, ТЭЗҮ-гүй 196 тэрбум, санхүүжилтийг хэрэгжүүлэх хугацаатай нь уялдуулаагүй 409 тэрбум төгрөг Их Хурал дээр орж ирээд ажлын хэсэг дээр Төсвийн байнгын хороо бусад Байнгын хороон дээр ажиллахдаа төсвийн хуулийн шаардлагад нийцээгүй 165 тэрбум төгрөг, бүсчилсэн хөгжлийг дэмжих нэрээр 224 тэрбум төгрөг ингээд нийтдээ 1 их наяд орчим төсөл арга хэмжээг зарчимгүйгээр төсөвт тусгаад өнөөдөр батлах гэж байна. Үүн дээрээ бид нар анхаарах ёстой. Төлөвлөж чадахгүй бол хэрэгжүүлж чадахгүй ээ. Бид нар хаврын чуулганаар жилийн хөгжлийн төлөвлөгөө баталж байгаа 4 зарчмыг баримталмаар байна.

Нэгдүгээрт, жилийн хөгжлийн төлөвлөгөөнд тусаагүй төсөл арга хэмжээг төсөвт битгий суулга аа. Ажлын хэсэг дээр, Төсвийн байнгын хороон дээр битгий хүлээж ав аа.

Хоёрдугаарт, хөгжлийн төлөвлөгөөнд туссан бол тэдгээрийн ач холбогдол эрэмбийг гаргах ёстой.

Гуравдугаарт, үүн дээрээ үндэслээд Сангийн яам төсвөө боловсруулахдаа энэ эрэмбийг бас хамтад нь оруулж ирээд хасаж болох төсөл юм уу, үнийн дүнг нь бууруулж болох юм уу үгүй юм уу гэдгийг нь ярилцдаг бодлогын мэтгэлцээнийг энэ Их Хурал дээр өрнүүлэх хэрэгтэй байна.

Дөрөвдүгээрт, 5 жилийн үндсэн чиглэлийг Учрал сайд өргөн барьсан. Өмнөх 5 жилийнхтэй харьцуулах юм бол хамаагүй сайн бүтэцтэй агуулгатай орж ирсэн байна. Баярлалаа.

Салбарын яамдууд төрийн албан хаагч нар, зөвлөхөөр ажилласан хүмүүс, дээрээс нь шинжлэх ухааны хамт академийн хамт олонд бас баярлалаа гэж хэлмээр байна.

Цаашид энэ 5 жилийн үндсэн чиглэлийн шалгуур үзүүлэлтийг ахиулахгүй байх юм бол тийм төсөл арга хэмжээг төсөв дээр тавихгүй байх ёстой. Тэгж байж бид нар зөв төлөвлөдөг эрэмбэ дараагаа зөв гаргадаг. Энэ нь нийгэм эдийн засагт үр дүнгээ өгдөг ийм төсвийн хэлэлцэх боломж нь Их Хурал дээр бүрдэнэ ээ. Бид ийм үр дүнд суурилсан зарчмыг баримтлаад ажил хэрэгчээр бодлогын мэтгэлцээн өрнүүлж байж иргэдийн ААН-ийн төлж байгаа татварыг үр дүнтэй зарцуулах боломж нь бүрдэнэ. Салбарын асуудлууд шийдэгдэнэ нийгэм эдийн засгийн нөхцөл байдал сайжирна аа.

Тэгэхээр цаашдаа бүгдээрээ энэ дээр анхаарч явмаар байна гэсэн уриалгыг хэлье ээ. Баярлалаа.

**Б.Пүрэвдорж:** Үг хэллээ. Өлзийхүүгийн Шижир гишүүн асуулт асууна.

**Ө.Шижир:** Монголын парламентын түүхэнд анх удаа Улсын Их Хурлын даргагүй төсөв баталж байна. Үүний шалтгаан бол МАН төсвийн хэлэлцүүлгийн 56 хоног хоорондоо ямбийтэл зодолдсоны үр дүнд бас Улсын Их Хурлын дэд дарга төсөв баталж байгаа юм. Тэгээд би Пүрэвдорж даргад баяр хүргэмээр байгаа юм. Та энэ хугацаанд улсын төсвийг 30 гаруй хоногт нь 2 хуваагдлаас болгоод гацаачихсан, хэлэлцэхгүй, хэлэлцүүлгүүдийг нь явуулдаггүй ийм бойкот хийчихсэн байх үед та зарчмыг барьж амжилттай энэ төсвийг хэлэлцүүлээд дуусаж байна аа. Танд баяр хүргэе. Танд баяр хүрмээр байгаа юм.

Ер нь бол цаашдаа наад индэр дээр чинь АН-ын хүн байх юм бол бас 1 дүгээрт Их Хурлыг гоё харагдуулаад, 2 дугаарт бас ийм зарчимтай удирдах юм байна. Та нарын хуваагдлаас чинь болоод төсөв үндсэндээ 56 хоног гацсан. Та нар нэг их Монголчуудад хайртайдаа голын 2 эрэг дээр гарчхаад бие бие рүүгээ чулуу шидээгүй шүү дээ. Эрх мэдлээ булаацалдсан байхгүй юу. Төсвийн 122 их наядын үнэлгээтэй ТӨК болон төрийн хөрөнгийг хэн хяналтгүйгээр удирдах вэ гэдэг эрхээ булаацалдсан юм. Та нар нэг их Монголчуудад хайртайдаа ингэж хийгээгүй юм. Ер нь гартаа бензин барьчихад гал унтраана гэж байдаггүй юм шүү дээ. Худлаа хайр зарлаад. Ам ангайхаараа Монголчуудын эрх ашиг яриад бодит байдал дээрээ төсвөөрөө барьцаалж 2 тийшээ хуваагдаад.

Өнөөдөр энэ төсвийг чинь харин АН-ынхан авч гарч байгаа шүү. Улсын Их Хурал Үндсэн хуулийн зөрчилд орохгүй байх энэ боломжийг АН-ынхан өнөөдөр бий болгож өгч байгаа шүү. Тэгэхгүй тэгээд л нэг сонин сонин улс төржсөн мэдэгдлүүд хийгээд л ээлжилж хэвлэлийн хурал хийгээд л. Та нар сүүлийн 10 жил эрх барьж байгаа шүү дээ. 2016 оноос хойш та нарын зарцуулсан мөнгө 197 их наяд төгрөг байгаа. Бараг 200 их наяд. Зөвхөн 2024, 2025, 2026 гуравхан оныг харьцуулах юм бол та нар 100 их наяд төгрөг гарын салаагаар урсгасан. Та нарын гайхаад байгаа энэ намынхан чинь та нар нэг л намынхан шүү дээ. Зөвхөн сүүлийн 3 жилд та нар 100 их наяд төгрөгөөр захиран зарцуулчихаад асуудлаа шийдсэн нэг салбар ч

байхгүй. Бие биеэ гайхаад. Анх удаагаа улсын төсвөөр бойкот хийсэн. Анх удаагаа улсын төсвийг хэлэлцүүлэхгүй байхыг байнгын хороо болон эл хэвлэлийн хурлаас шаардсан ийм төсөв анх удаагаа бас гарч ирлээ.

Тэгээд 2026 оны төсөв дээр урсгал зардлаа танах ямар ч юм орж ирээгүй. Ерөнхий тоо л орж ирсэн. Би нэг та нарт хэдэн тоо хэлж өгье. Цахим яам гэж байгуулагдсанаас хойш бичиг хэргийн зардал 20 тэрбум болсон. 10 тэрбумаас. Хаана байна тэр цахим шилжилт. Улсын төсвөөс санхүүждэг 480 орчим байгууллага. 2016 онд та нарыг эрх авахад 950 тэрбум төгрөгийн урсгал зардалтай байсан. Өнөөдөр 4.5 их наяд болсон. Зөвхөн сүүлийн 3 жилд төсөвт өртгөө нэмэгдүүлсэн өртөг чинь 2 их наядаар нэмэгдэж байгаа. Зөвхөн 2026 оны төсөв дээр анхны төсвөөсөө 805 тэрбумаар нэмэгдэж байгаа юм. Үүний цаана авлига л байгаа. Яахаараа зөвхөн сүүлийн 3 жилд 2 их наяд орчим нэмэгддэг юм. Сүүлийн 10 жилд 1062 ширхэг та нар сургууль цэцэрлэгийн боловсролын салбарт биш хөтөлбөрт барилга байшин барьсан. Энэ чинь 2.8 их наядаас 3.4 их наяд 600 тэрбумаар нэмэгдсэн. Төрийн үйлчилгээний барилга гэж 750 тэрбум нэмэгдсэн. Зөвхөн Орхон аймгийн бусдаар гүйцэтгүүлсэн арга хэмжээ 900 сая төгрөгөөс 12 тэрбум бас нэмэгдсэн. Хамгийн багадаа 214 хувь нэмэгдсэн. Тэгээд энэ хугацаанд та нар л эрх барьсан юм шүү дээ. Та нар л энэ хугацаанд бүх хөрөнгийг үрэн таран хийсэн юм шүү дээ. Та нарын сая төсөв гацааж байсан 56 хоногт эмч, багш нарын нийгмийн асуудал болно. Цаашдаа төрийн бүх албан хаагчийн нийгмийн асуудлыг шийдэх хэлэлцээр хийх боломжтой хугацаа байсан байхгүй юу.

**Б.Пүрэвдорж:** Шижир гишүүн нэг минут нэмж тодруулъя.

**Ө.Шижир:** 60 орчим их наядын хөрөнгөтэй ТӨК-уд бол танай намын үүр болсон. Тэнд 119 төрийн өмчит байгууллага дээр нийт зардлын тэлэлт ямар байна аа гээд бичиг өгөхөөр өгдөггүй. Одоо 45 хоногтоо явж байна. Бараа үйлчилгээний зардал чинь одоо би та нарт зөвхөн нийслэлийн жишээ хэлж өгье. 2017 онд 88 тэрбум байсан бусдаар гүйцэтгүүлсэн арга хэмжээ чинь өнөөдөр 272 тэрбум болчихсон байгаа. Та нар түүнээсээ ч засаг авсан. Орхон аймгийн байр ашиглалтын зардал гэхэд 303 сая төгрөг байсан. Өнөөдөр 1.4 болсон. Зөвхөн эд хогшил засвар нь 337 саяас 3.5 тэрбум болсон. Зөвхөн Орхон аймаг энэчээ. Ингэж та нар гарын салаагаар урсгасан байхгүй юу. Төсвөө данхайлгаад л байсан. Урсгал зардлаа нэмээд л байсан. Бүр хөрөнгө оруулалтын зардал огт байхгүй.

**Б.Пүрэвдорж:** Бусдаар гүйцэтгүүлэх ажил чинь өнгөрсөн жилийн төсөв дээр бараг 1 их наяд байсан юм. Нэг аймгийнх. Одоо Бадамдоржийн Пунсалмаа гишүүн асуулт асууна.

**Б.Пунсалмаа:** Эрхэм гишүүд та бүхэнд энэ өдрийн амар амгаланг айлтгая.

2026 оны Монгол Улсын төсөв батлагдаж байна л даа. Тэгээд бид нар төлөвлөгдсөн төсвөөсөө 1.1 их наядыг багасгаж байгаад багш нарынхаа цалинг нэмсэн. Ахмадуудынхаа тэтгэвэр тэтгэмжийг 8.5 хувиар нэмж байгаа юм. Залгуулаад одоо энэ эмч нар маань бас цалин нэмнэ гээд ингээд хөдөлгөөн өрнүүлээд эхэлчихлээ. Ер нь бүх салбаруудын цалин нэмэх шаардлагатай болдог юм аа. Хувийн хэвслүүдийн цалин нэмэгдэх шаардлагатай болдог дагаад нэмэгддэг. Яах вэ энэ цалин нэмж байгаа өөр бас сайн үр дүнгүүд байдаг аа гэж хэлсэн. Эргээд нийгмийн даатгал, НӨАТ, гааль хэлбэрээр төсөвт орлого ороод ирчихдэг юм цалин нэмэгдэхээр. Гол нь би энд сууж байгаа эрхэм төсвийн

ерөнхийлөн захирагч нараас асуух гээд байгаа юм. Та бүхэн минь Монголд энэ үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүн, Монгол үйлдвэрлэгч нараа хэрхэн дэмжих юм бэ? Та бүхэн энэ төрийн худалдан авалтаар энэ Монгол үйлдвэрлэгч нараа хэрхэн дэмжих талаараа энд танхимд сууж байгаа төсвийн Ерөнхийлөгч захирагч нар та бүхэн өөр өөрсдийнхөө энэ жилд захиран зарцуулах хэмжээнээсээ хэдий хэмжээг Монгол үйлдвэрлэгч нарт зориулахаа нэг хэлээд явчих уу? Одоо энэ танхимд ер нь хэдэн сайд нар байна?

Тэгэхээр сайд нараасаа 4 сайд нараа сонсьё. Энэ танхимд байхгүй байгаа сайд нараас бас бид нар бичгээр энэ хариултыг авъя. Тэгээд үйлдвэрлэгч нартаа бас харуулъя. Энэ бол төр бол хамгийн том үндэсний үйлдвэрлэгч нарыг дэмжих том хүч, эх оронч худалдан авалт гэдгийг бид нар төрөөсөө бид нар өөрсдөөсөө эхлүүлэх хэрэгтэй байгаа шүү.

**Б.Пүрэвдорж:** Боловсролын сайд.

**П.Наранбаяр:** Пунсалмаа гишүүний асуултад хариулъя. Ер нь бол төсвийн мөнгө өөрөө дотоодынхоо ААН-үүдэд бас орлого олж орж байвал энэ маш сайн ийм цикл эхэлнэ гэж харж байгаа. Энэ утгаараа жишээлбэл манай салбарт бол тоног төхөөрөмжийн зардал дээр ер нь сандал ширээ мөн гал тогооны тоног төхөөрөмжүүд байдаг. Энэ тендер шалгаруулах явцад бол ер нь дотоодын ААН-үүдийг илүү дэмжих тэдний үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүн бүтээгдэхүүний худалдан авах ийм бодлого явагддаг аа гэдгийг танд хэлье ээ. Баярлалаа.

**Б.Пүрэвдорж:** Бусад сайд нараас тэгээд бичгээр авчхаарай. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, ЭМД-ын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн 4 дэх хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, ЭМД-ын сангийн 2026 оны төсвийн тухай хуулиуд хуулийн төслүүдийн 5 дахь хэлэлцүүлгийг явуулна.

Төсвийн байнгын хороо төсвийн төслүүдийг 5 дахь хэлэлцүүлэгт бэлтгэн гишүүдэд тараасан байгаа. Гишүүд санал хураалтад бэлтгэе.

Гишүүдийн олонхоор буюу 64-өөс дээш гишүүний саналаар бүгд батлагдана. Ирцээ сайжруулаарай.

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төслийн зүйл заалт бүрийг уншин сонсгож зүйл тус бүрээр санал хураалт явуулна.

## **МОНГОЛ УЛСЫН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ**

### **НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

## 1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын төсөвт 2026 оны төсвийн жилд төвлөрүүлэх орлого, зарцуулах төсвийн хэмжээ, орлого төвлөрүүлэх байгууллага, орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг, Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон улсын төсвөөс Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг, орон нутгийн төсвөөс улсын төсөвт төвлөрүүлэх орлого, төсвийн ерөнхийлөн захирагчид төсөв зарцуулах эрх олгох, Төсвийн тогтворжуулалтын санд хуримтлуулах хөрөнгийн хэмжээ, төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр, мөнгөн гүйлгээтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Санал хураалт.

96 гишүүнээс 72 гишүүн дэмжиж, 75.0 хувиар санал дэмжигдлээ.

## 2 дугаар зүйл.Монгол Улсын 2026 оны төсвийн хууль тогтоомж

2.1.Монгол Улсын 2026 оны төсвийн хууль тогтоомж нь Төсвийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

Санал хураалт.

96 гишүүнээс 74 гишүүн дэмжиж, 77.1 хувиар санал дэмжигдлээ.

## ХОЁРДУГААР БҮЛЭГ

### МОНГОЛ УЛСЫН 2026 ОНЫ ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА БОЛОН ХӨРӨНГӨ, ӨРИЙН УДИРДЛАГА

3 дугаар зүйл.Монгол Улсын төсөвт 2026 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч, түүний харьяа болон бусад байгууллага доор дурдсан орлогыг төвлөрүүлнэ:

| Д/д | Төсвийн ерөнхийлөн захирагч                                                                                                | Дүн<br>/сая<br>төгрөгөөр/              |
|-----|----------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------|
| 1   | <b>Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга</b><br>Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого                         | <b>185.0</b><br>185.0                  |
| 2   | <b>Монгол Улсын Их Хурлын дарга</b><br>Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого                                            | <b>100.0</b><br>100.0                  |
| 3   | <b>Монгол Улсын Ерөнхий сайд</b><br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар<br>Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого | <b>85,422.8</b><br>81,600.0<br>3,822.8 |
| 4   | <b>Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга</b><br>Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого                                         | <b>510.0</b><br>510.0                  |
| 5   | <b>Төрийн албаны зөвлөлийн дарга</b><br>Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого                                           | <b>200.0</b><br>200.0                  |
| 6   | <b>Санхүүгийн зохицуулах хорооны дарга</b>                                                                                 | <b>4,002.9</b>                         |

|    |                                                                                                                                                                                                                                                                |                                                                                                      |
|----|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------|
|    | Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого                                                                                                                                                                                                                       | 4,002.9                                                                                              |
| 7  | <b>Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд</b><br>Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого                                                                                                                                           | <b>13,918.4</b><br>13,918.4                                                                          |
| 8  | <b>Монгол Улсын Шадар сайд</b><br>Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого                                                                                                                                                                                     | <b>20,872.8</b><br>20,872.8                                                                          |
| 9  | <b>Монгол Улсын Шадар сайд</b><br>Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого                                                                                                                                                                                     | <b>115.9</b><br>115.9                                                                                |
| 10 | <b>Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга</b><br>Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого                                                                                                                                                 | <b>300.0</b><br>300.0                                                                                |
| 11 | <b>Гадаад харилцааны сайд</b><br>Дипломат төлөөлөгчийн газрууд<br>Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого                                                                                                                                                     | <b>6,100.0</b><br>6,000.0<br>100.0                                                                   |
| 12 | <b>Сангийн сайд</b><br>Татварын ерөнхий газар<br>үүнээс: Төсвийн тогтворжуулалтын санд<br>Гаалийн ерөнхий газар<br>Сангийн яам<br>Гадаад тусламжийн орлогоос санхүүжих<br>Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого                                             | <b>19,064,084.1</b><br>10,030,214.1<br>367,653.5<br>8,358,545.0<br>303,299.4<br>365,000.0<br>7,025.6 |
| 13 | <b>Хууль зүй, дотоод хэргийн сайд</b><br>Улсын бүртгэлийн ерөнхий газар<br>Цагдаагийн ерөнхий газар<br>Шүүх шинжилгээний ерөнхий газар<br>Эрүүл мэндийн даатгалын сангаас улсын эмнэлэгт олгох санхүүжилтийн орлого<br>Харьяа төсөв байгууллагын өөрийн орлого | <b>64,847.1</b><br>25,000.0<br>2,500.0<br>300.0<br><br>1,052.5<br>35,994.6                           |
| 14 | <b>Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд</b><br>Ашигт малтмал, газрын тосны газар<br>Үндэсний геологийн алба<br>Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого                                                                                                             | <b>339,573.8</b><br>293,986.9<br>160.0<br>45,427.0                                                   |
| 15 | <b>Батлан хамгаалахын сайд</b><br>Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого                                                                                                                                                                                     | <b>42,760.7</b><br>42,760.7                                                                          |
| 16 | <b>Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд</b><br>Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого                                                                                                                                                               | <b>2,209.7</b><br>2,209.7                                                                            |
| 17 | <b>Боловсролын сайд</b><br>Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого                                                                                                                                                                                            | <b>5,534.8</b><br>5,534.8                                                                            |
| 18 | <b>Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд</b><br>Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого                                                                                                                                                               | <b>284.0</b><br>284.0                                                                                |
| 19 | <b>Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд</b><br>Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар<br>Эрүүл мэндийн даатгалын сангаас улсын эмнэлэгт олгох санхүүжилтийн орлого<br>Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого                                  | <b>55,974.8</b><br>1,500.0<br><br>2,608.0<br>51,866.8                                                |
| 20 | <b>Зам, тээврийн сайд</b>                                                                                                                                                                                                                                      | <b>72,300.0</b>                                                                                      |
Эдийн засгийн тодорхойгүй байдал хямралын үед бодлогын өөрчлөлтийг хэрэгжүүлэхэд иргэд, бизнес, хөрөнгө оруулагчийн итгэл зайлшгүй чухал. Итгэл байхгүй бол бодлогын үр нөлөө суларч, эдийн засгийн хямрал гүнзгийрдэг гэдгийг ухамсарлаж ажиллахыг нийт гишүүдээсээ бас дахин хүсье ээ.

Төсөв бол ялсан намыг санхүүжүүлэх хэрэгсэл ердөө биш. Энэ утгаараа 2026 оны төсөв нэг намын биш харин Монгол Улсын төсөв боллоо гэж дүгнэж байна аа. Төсөв бол улс орныг хөгжүүлэх нийгэм эдийн засгийг удирдах бодлогын баримт биш гэдгийг гишүүддээ дахин санал сануулъя.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Өнөөдрийн бас энэ төсвийг ингэж 1.1 их наядаар танаж бас тэндээсээ ихэнхийг нь 900 орчим тэрбум төгрөгийг багш, эмч нарын цалин нэмэгдүүлэх мөн түүнчлэн тэтгэврийг нэмэгдүүлэхэд зарцуулсан санал оруулсан Сангийн яамны сайд Жавхлан болон ажлын хэсгийн дарга Ганхуяг нартаа болон нийт Их Хурлын гишүүддээ бас тал дахин талархал илэрхийлье ээ.

Яг 17 цаг 50 минут болж байна.

Тэгээд өнөөдрийн чуулганы хуралдааныг үргэлжлүүлж явуулъя.

Гишүүд дэмжиж байна уу? Олонх нь дэмжиж байна.

17.50 цаг

Хэлэлцэх асуудал 4. “Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл Улсын Их Хурлын гишүүн Л.Оюун-Эрдэнэ нарын 33 гишүүн 2025 оны 10 сарын 6-ны өдөр өргөн мэдүүлсэн үргэлжилж байгаа. Үргэлжлүүлэн хэлэлцэнэ.

Энэ дээр маш их олон асуудлууд гарсан. Би тэгээд хуулийн тодорхой заалтуудыг та бүхэнд танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 7.5-д Монгол Улсын үндсэн хуулийн тодорхой заалтыг илтэд зөрчсөн, зөрчсөн асуудал хэлэлцсэн, эс үгүй бол Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахыг эсэргүүцэхээс бусад шалтгаанаар нам, эвслийн бүлэг гишүүн хуралдаанд оролцохгүй байх буюу түүнийг орхин гарахыг хориглоно оо гэж заасан байгаа.

10, 11-нд тухайн өдрийн хуралдаан эхлэхэд ирцэд бүртгүүлсэн гишүүн чөлөө аваагүй, хүндэтгэн үзэх болон энэ хуулийн 7.5-д заасан эсэргүүцэх шалтгаантайгаа мэдэгдэлгүй хуралдааныг орхиж гарсан, эс үгүй бол бүртгэлээс гарсан бол түүнийг

хуралдааны ирцэд оруулж тухайн асуудлаар санал хураахад эсрэг санал өгсөнд тооцно оо гэж заасан байгаа.

4.1.3-д горимын санал гэж Улсын Их Хурлын гишүүнээс зөвхөн хэлэлцэж буй асуудлаар болон тухайн асуудлыг хэлэлцэх дараалал, журмын талаар гаргасан саналыг гэж заасан. Пүрэвдаваа гишүүн асуудлыг хэлэлцэж дууссаны дараа санал хураалт дахин өгөх санал гаргасан байна.

Мөн Пүрэвдаваа гишүүн дэгийн тухай хуулийн 7.5-д заасан асуудлаар ямарваа нэгэн эсэргүүцэх шалтгаантайгаа мэдэгдэж хуралдааныг орхиж гараагүй, мөн чөлөө аваагүй, хүндэтгэн үзэх шалтгаан илэрхийлээгүй тул түүнийг хуралдааны ирцэд орсон улмаар эсрэг санал өгсөн гэж тооцож байна.

Иймд дахин санал хураалт явуулах боломжгүй байна аа. Тэгээд чуулганы танхимыг би бүрэн хянах боломжгүй.

2015 оны 11 сарын 7-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанд Пүрэвдаваа гишүүн 11 цаг 8 минутад чуулганы танхимыг сайн дураар орхин гарсан байна. Хянан шалгах хороо түр хороо байгуулах тогтоолыг батлах санал хураалт хамгийн сүүлд 11.46-д явагдаж, 46 гишүүн дэмжиж, 46 гишүүн татгалзсан байна.

12 цагт буюу дэмжигдээгүй саналаас даруй 14 минутын дараа Пүрэвдаваа гишүүн горимын санал гаргасан.

Иймд дэгийн тухай хуулийн 4.1.3, 7.5, 10.1 дүгээр заалтыг үндэслэн Д.Пүрэвдаваа гишүүний гаргасан горимын саналыг хүчингүйд тооцлоо. Иймд 11 цаг 46 минутад явагдсан 46 гишүүн дэмжиж 46 гишүүн татгалзсан саналыг хүчинтэйд тооцож Түр хороо байгуулах тогтоол батлагдсангүй.

17.55 цаг

Хэлэлцэх асуудал 5. [Монгол Улсын Их Хурлын дэд даргыг огцруулах тухай асуудлыг үргэлжлүүлэн хэлэлцэнэ.](#)

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан 2025 оны 11 дүгээр сарын 5-ны өдөр Улсын Их Хурал дахь АН-ын бүлэг ажлын 5 өдрийн завсарлага авсан. Завсарлагын хугацаатай холбоотой Цогтгэрэл дарга үг хэлэх үү? Огцруулах тухай асуудал. Цогтгэрэл гишүүнд микрофон өгье, үг хэлье.

**О.Цогтгэрэл:** Энэ асуудлаар Улсын Их Хурлын дэд даргыг огцруулах, томилох, сонгох асуудлаар АН-ын бүлгээс өнгөрсөн 7 хоногт бас тодорхой байр суурь илэрхийлсэн. Энэ нь Үндсэн хуулийн талд Үндсэн хуулийн энэ цэцийн их суудлын хуралдааныг хүлээн зөвшөөрч биелүүлж ажиллах ёстой гэдэг энэ зарчмын байр суурь тодорхой байр суурийг илэрхийлж ажиллаж байгаа. Мөн энэ асуудлын цаана бас утга агуулгууд бас бий. Энэ нь зөвхөн нэг өнөөдрийн бид нарын хэлэлцэж байгаа дэд даргыг огцруулах төдий асуудал бас биш. Энэ хууль хоорондын нийцлийн асуудал, Үндсэн хуульд хуулиудыг нийцүүлэх, хууль хоорондын зөрчлийг арилгах түвшнийг нь системийн ажлыг бид нар энэнд хийх ёстой гэж бас АН-ын бүлгээс энэ асуудал дээр үзэж байгаа. Тэгээд өнөөдрийн энэ хэлэлцэх асуудлын хувьд хэлэлцэх асуудлын дараалалд Улсын Их Хурлын дэд даргыг огцруулах,

шинээр сонгох эсэх асуудал бас ингээд ороод хэлэлцэгдээд явж байна. Энэ асуудал дээр АН-ын бүлгээс 5 хоногийн завсарлага авсан.

Ер нь зарчмын байр суурийн хувьд энэ бол тусдаа асуудал. Дэд даргын асуудал, дэд даргаас чөлөөлөгдөх асуудал тусдаа асуудал. Энэний цаана Үндсэн хуулийн их суудлын хуралдаанаас ямар үр дагавар бүхий шийдвэр гарсан. Улсын Их Хурлын дэд даргыг Улсын Их Хурлын гишүүнийхээ хувьд эргүүлэн татах, хуулийн бусад хариуцлагын асуудлууд бүгдээрээ энэний цаана нээлттэй байгаа гэж үзэж байгаа. Ийм учраас АН-ын бүлгийн хувьд бас энэ зарчмын байр суурь дээрээ хэвээр байгаа гэдгийгээ бас илэрхийлье ээ.

**Б.Пүрэвдорж:** Үг хэллээ. МАН-ын бүлгийн Улсын Их Хурлын дэд даргыг огцруулах хүсэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь МАН-ын бүлгийн дарга Жигжидийн Батжаргал танилцуулсан.

Монгол Улсын Их Хурлын дэд даргыг огцруулах санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтад бэлтгэе.

Санал хураалт.

Монгол Улсын Их Хурлын дэд даргыг огцруулах санал хураалтын дагуу 99 гишүүнээс 62 гишүүн дэмжиж 62.6 хувиар санал дэмжигдлээ.

Замира гишүүн, Аубакир гишүүн, Мөнхсоёл гишүүн, Жавхлан гишүүдийг дэмжсэнээр санал авах уу. Дамдины Цогтбаатар гишүүн.

Би томъёоллоо уншаагүй юм байна шүү.

Хүрэлбаатарын Булгантуяаг Монгол Улсын Их Хурлын дэд даргын үүрэгт ажлаас огцруулахыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураая.

99 гишүүнээс 66 гишүүн дэмжиж 66.7 хувиар санал дэмжигдлээ. Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн дэмжсэн, Дамдины Цогтбаатар гишүүн дэмжсэн.

Улсын Их Хурлын дэд даргыг огцруулах хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Монгол Улсын Их Хурлын дэд даргыг огцруулах тухай тогтоолыг уншъя.

Монгол Улсын Их Хурлын тогтоол

Монгол Улсын Их Хурлын дэд даргыг огцруулах тухай

Монгол Улсын үндсэн хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь:

1.Монгол Улсын Их Хурлын гишүүн Хүрэлбаатарын Булгантуяад хариуцлага, хүрэл хүлээлгэж Монгол Улсын Их Хурлын дэд даргын үүрэгт ажлаас огцруулсугай. Энэ тогтоолыг 2025 оны 11 дүгээр сарын 12-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Санал хураалтын дагуу Улсын Их Хурлын дэд даргыг огцруулах хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Монгол Улсын Их Хурлын дэд даргыг огцруулах тухай Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцлоо.

Тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүд байна уу? Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

18.03 цаг

Хэлэлцэх асуудал 6. Монгол Улсын Их Хурлын дэд даргыг сонгох тухай асуудал.

МАН-ын бүлгээс Улсын Их Хурлын дэд даргад нэр дэвшүүлэх саналыг Улсын Их Хурлын гишүүн Улсын Их Хурал дахь МАН-ын бүлгийн дарга Жигжидийн Батжаргал танилцуулна. Таныг индэрт урьж байна.

**Ж.Батжаргал:** Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн 24 дүгээр зүйлийн 1, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсгийг тус тус үндэслэн УИХ дахь МАН-ын бүлгээс Улсын Их Хурлын гишүүн Жадамбын Бат-Эрдэнийг Улсын Их Хурлын дэд даргад нэр дэвшүүлж байна.

Жадамбын Бат-Эрдэнэ 1965 онд төрсөн эхнэр хүүхдүүдийн хамт амьдардаг. 1983 онд нийслэлийн 75 дугаар дунд сургууль, 1989 онд ОХУ-ын Эрхүү хотын Политехникийн дээд сургууль, 1998 онд МУИС-ийн Хууль зүйн сургуулийг тус тус төгссөн. Автын инженер, эрх зүйч мэргэжилтэй. 1990-1992 онд ОХУ-ын Рибкоп УҮГ-т менежерээр, 1994-2000 онд Ашид Эрдэнэ ХХК-ийн захирлаар, 2000-2004 онд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Авто тээврийн газрын даргаар, 2007-2012 онд Зам тээвэр АЖЯ-ны ТНБД-аар, 2008-2012 онд Монголын төмөр зам ТӨХК-ийн ТУЗ-ийн даргаар, 2011-ээс 2012 онд МИАТ ХК-ийн ТУЗ-ийн даргаар тус тус ажилласан.

Жадамбын Бат-Эрдэнэ 2016, 2020 онд Булган аймгаас, 2024 онд хойд бүсийн иргэдийн итгэлийг хүлээж Улсын Их Хурлын гишүүнээр 3 удаа сонгогдсон бөгөөд 2017-2018 онд Монгол Улсын Засгийн газрын гишүүн, зам тээврийн хөгжлийн сайдаар, 2024-2025 онд Монгол Улсын Их Хурлын ТББХ-ны даргаар, 2025 оны 6 дугаар сараас Монгол УИХ дахь МАН-ын бүлгийн даргаар сонгогдон ажилласан туршлагатай.

Эрхэм гишүүд ээ, УИХ дахь МАН-ын бүлгээс Улсын Их Хурлын гишүүн Жадамбын Бат-Эрдэнийг парламентад ажилласан байдал, боловсрол мэдлэг, туршлага зэргийг харгалзан үзэж Улсын Их Хурлын дэд даргад нэрийг нь дэвшүүлж байна аа. УИХ дахь МАН-ын бүлгийн саналыг дэмжин шийдвэрлэж өгөхийг та бүгдээсээ хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

**Б.Пүрэвдорж:** Батжаргал даргад баярлалаа.

Монгол Улсын Их Хурлын дэд даргыг сонгох санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтад бэлтгэе.

Тэгэхээр Улсын Их Хурал дахь бүлгүүд өөрсдийнхөө бүлэг дотроо санал хураасны дагуу Их Хурлын дарга болон бүлгийн дарга нарыг томилж оруулж ирдэг. Аль аль бүлгүүд нь өөрсдийнхөө тэр гаргасан саналд хүндэтгэлтэй ханддаг. Тийм учраас бол МАН-ын бүлгийн гишүүдийн 100 хувийн саналын дэмжлэгтэйгээр дэд даргад дэвшиж орж ирж байгаа Бат-Эрдэнийг бүгдээрээ дэмжиж санал өгөхийг та бүхэнд хүсэж байна аа. Уриалж байна аа. Баярлалаа.

Монгол Улсын Их Хурлын дэд даргаар Жадамбын Бат-Эрдэнийг сонгохыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана.

100 гишүүнээс 78 гишүүн дэмжиж, 78 хувиар санал дэмжигдлээ.

Батболд гишүүн, Жудгийн Баярмаа гишүүн, Батчимэг гишүүн, Батсуурь гишүүн, Хэрлэн гишүүн нар дэмжсэнээр протоколд тэмдэглүүлэхийг хүсэж байна.

Бат-Эрдэнэ гишүүн дэд даргынхаа суудалд ирж суухыг урьж байна.

Түрүүн би Булгантуяагийн тогтоолын төсөл дээр 2025 оны 11 сарын 11 гэж уншсан байна. 12-ны өдрөөс гэж залруулж байна.

Их Хурлын дэд даргаар Жадамбын Бат-Эрдэнийг сонгохыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Монгол Улсын Их Хурлын дэд даргыг сонгох тухай Улсын Их Хурлын тогтоол баталсанд.

Тогтоолыг уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын дэд даргыг сонгох тухай

Монгол Улсын үндсэн хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 21 дүгээр зүйл болон санал хураалтын дүнг үндэслэн Улсын Их Хурлаас тогтоох нь:

Улсын Их Хурал дахь МАН-ын бүлгээс нэр дэвшүүлсэн Улсын Их Хурлын гишүүн Жадамбын Бат-Эрдэнийг Монгол Улсын Их Хурлын дэд даргаар сонгосугай.

2.Энэ тогтоолыг 2025 оны 11 дүгээр сарын 12-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Тогтоолыг баталсанд тооцлоо. Тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Төрийн байгуулалтын байнгын хороо хуралдана. 18.30-д чуулганы хуралдаан дахин хуралдаж Монгол Улсын Их Хурлын даргын үүрэг гүйцэтгүүлэх тухай тогтоолыг хэлэлцэнэ. Төрийн байгуулалтын байнгын хороо Жанжин Сүхбаатар танхимд.

ЗАВСАРЛАГА

**Б.Пүрэвдорж:** Дараагийн асуудалд оръё.

Хэлэлцэх асуудал 7.

“Монгол Улсын Их Хурлын даргын үүрэг гүйцэтгүүлэх” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Төслийн талаарх ТББХ-ны санал дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Сандаг-Очир танилцуулна. Индэрт урьж байна.

**Ц.Сандаг-Очир:** Улсын Их Хурлын дэд дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын 2025 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэгт заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнийг Улсын Их Хурлын дэд даргаар сонгосон. Улсын Их Хурлын гишүүн Улсын Их Хурлын дэд дарга Ж.Бат-Эрдэнэд Улсын Их Хурлын даргыг шинээр сонгох хүртэл хугацаанд түүний албан үүргийг гүйцэтгүүлэх асуудлыг шийдвэрлэхээр болсон.

Иймд Төрийн байгуулалтын байнгын хороо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсгийг баримтлан Монгол Улсын Их Хурлын даргын үүрэг гүйцэтгүүлэх тухай тогтоолын төслийг 2025 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

ТББХ-ны хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын даргын үүрэг гүйцэтгүүлэх тухай тогтоолын төслийг дэмжих талаар ил санал хурааж хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын даргын үүрэг гүйцэтгүүлэх тухай тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх ТББХ-ны санал, дүгнэлтийг хэлэлцэн тогтоолын төслийг баталж өгөхийг та бүхнээс хүсье ээ.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

**Б.Пүрэвдорж:** Сандаг-Очир гишүүнд баярлалаа.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгнө үү. Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

**С.Эрдэнэболд:** Би үг хэлчихье. Монгол төрийн босго Үндсэн хууль дээр тангараг өргөсөн хүмүүсийн бүхий л үйл ажиллагаа өндөр ёс, зүйтэй, хариуцлагатай, ил тод байхыг ард түмэн шаардсаар байгаа юм аа. Орой болсон байна, цаг давчуу байна гээд шудраад шуураад явж болно оо. Гэхдээ 1992 оны 1 сарын 13-ны өдрийн 11 цаг 35 минутад батлагдсан Үндсэн хуулийн 33 жилийн ой дээр энэ Үндсэн хуулийн үнэт зүйлийг сорилт болсон өдрүүд өнгөрсөн сар гарны хугацаанд болсон юм аа.

Тийм учраас Монгол Улсын засаглалын салаа мөчрийн нэг болох хууль тогтоох байгууллагыг тэргүүлэх гэж байгаа тодорхой хугацаанд даргын үүргийг гүйцэтгэж байна гэдэг бол асар өндөр итгэл үнэмшил хийгээд ёс зүй шаардсан ажил аа.

Тийм учраас эрх баригч намын бүлгийн зүгээс 100 хувийн саналаар Бат-Эрдэнэ гишүүнийг бас санал болгож байгаа. Монгол Улсын төр тунгалаг байх энэ парламент ёсны дархлааг хамгаалах хэлбэрэлтгүйгээр хамгаалах энэ итгэл үнэмшил бол ард иргэдэд байсаар байгаа. Гэхдээ сүүлийн үед парламентын нэр хүндэд халдах, хууль тогтоогч нарын санаатай болон санамсаргүй гаргаж байгаа үйлдэл ёс зүйгүй үйлдлээс болж Монголын парламентад итгэх иргэдийн итгэл унасаар байгаа.

Тийм учраас нэг үхрийн эвэр доргивол мянган үхрийн эвэр доргино гэдэг шиг нэг парламентын гишүүний ёс зүйтэй үйлдэл, эс үйлдэл нь ёс зүйгүй үйлдэл эс үйлдэл нь парламентат ёсны энэ дархлааг сулруулахад хүргэж байгаа юм. Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын 1.1.4 дээр энэ парламентат ёсны дархлаа бол өөрөө Монгол Улсын тусгаар тогтнол, эрх чөлөөт байдал, бүрэн эрхт байдлын баталгаа гэсэн зүйл байгаа юм. Энэ 2 том дэлхийн стратегийн тоглогч гүрний дунд байгаа цөөн хүн амтай эдийн засгийн хувьд уул уурхайгаас хэт хамааралтай жилийн 4 улиралтай гэсэн хэрнээсээ асар агуу түүхтэй асар том ирээдүйтэй Монгол Улсын хувьд иргэд нь эрх чөлөөтэй, итгэл үнэмшилтэй, чөлөөт нийгмийн үр шимийг хүртдэг хуулийн засаглалтай байх энэ дархан хилийн баталгаа бол хуулийн засаглал бөгөөд парламент ёсны дархлаа юм аа.

Тийм учраас өнгөрсөн хугацаануудад болж байгаа парламент ёсонд сорилт болж байгаа энэ үйл явдлуудыг цаашид нь зөв голдирол руу нь оруулж, парламентын хууль тогтоох, мөн хяналт тавих энэ бүрэн эрхийг нь итгэл төгс үргэлжлүүлэх иргэд олон нийтэд парламентын засаглалын тэр итгэл үнэмшилтэй зөв хуулийн дагуух энэ шударга ёсны тогтоогч байх энэ боломжийг нь илүү ахиулахад парламентыг удирдаж байгаа хүн, чиглүүлж байгаа хүн, хурлыг даргалж байгаа хүний итгэл үнэмшил асар чухал. Зөвхөн нэг удаагийн тохиолдол биш олон удаагийн тохиолдол дээр тэр парламентын спикерийн суудал дээр сууж байгаа хүнээс асар өндөр ёс зүйг шаардаж байгаа тэр моментууд түүнээ бас бид нар баталж хамгаалж хангаж чадаж байгаа эсэхтэй холбоотой энэ сорилтууд тулгамдсан юм аа.

Тийм учраас парламентыг удирдана гэдэг бол явцуурахгүйгээр аль нэгэн намын эрх ашиг гэхгүйгээр, аль нэгэн салбарын эрх ашиг гэхгүйгээр, Монгол Улсын нийт иргэдийн эрх ашиг Монгол түмний язгуур ашиг сонирхол эрмэлзлийн төлөө явж байх ёстой.

Тэгэхээр энэ итгэл үнэмшилдээ үнэнч байгаарай гэж Бат-Эрдэнэ гишүүнд хүсье. Монгол төрийн босго бол дандаа өндөр байж ирсэн. Энэ бол дэлхийг эзэлсэн Чингисийн төрийн үргэлжлэл юм. Гэхдээ өнөөдөр үүнтэй харьцуулахад манай ард иргэдийн амьдрал ажил амьжиргаа хангалтгүй байгаа юм аа. Тийм учраас Монгол төрийн төлөө, хууль ёсны төлөө өдрийн бодол шөнийн зүүд болж хичээн ажиллаасай, өргөсөн тангарагтаа үнэнч байгаасай гэдэг үгийг тэмдэглэлд үлдээж ийнхүү үг хэлж байгаа юм аа. Танд амжилт хүсье.

**Б.Пүрэвдорж:** Баярлалаа. Гишүүд асуулт асууж, хариулт авч үг хэлж дууслаа. Одоо Байнгын хорооны саналаар санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтад бэлтгэе.

Санал хураалт.

Байнгын хорооны саналаар Монгол Улсын Их Хурлын даргын үүрэг гүйцэтгүүлэх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураана.

Санал хураалт.

Цаас авч байгаад санал хураалтад орж амжсангүй. Би дэмжсэн шүү. Протоколд үлдээе.

Монгол Улсын Их Хурлын тогтоол

Монгол Улсын Их Хурлын даргын үүрэг гүйцэтгүүлэх тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь:

Монгол Улсын Их Хурлын даргыг шинээр сонгох хүртэл хугацаанд Улсын Их Хурлын даргын албан үүргийг гүйцэтгэж байхыг Улсын Их Хурлын дэд дарга Жадамбын Бат-Эрдэнэд даалгасугай.

Энэ тогтоолыг 2025 оны 11 дүгээр сарын 12-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй. Тогтоолын төслийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

100 гишүүнээс 80 гишүүн дэмжиж, 80 хувиар санал дэмжигдсэн. Би өөрийгөө оруулсан шүү.

18.56 цаг

Хэлэлцэх асуудал 8.

Монгол Улсын Засгийн газрын гишүүнийг огцруулах, томилох тухай Монгол Улсын ерөнхий сайдын танилцуулгыг хэлэлцэж эхэлье.

Засгийн газрын гишүүнийг огцруулах томилох тухай асуудлыг Монгол Улсын ерөнхий сайд Гомбожавын Занданшатар танилцуулна.

Монгол Улсын Ерөнхий сайд Гомбожавын Занданшатар таныг танилцуулга хийнэ үү гэж индэрт урьж байна.

**Г.Занданшатар:** Эрхэм Улсын Их Хурлын дэд дарга, Улсын Их Хурлын гишүүд ээ,

Монгол Улсын үндсэн хуулийн 39 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 23 дахь зүйлийн нэг дэх хэсгийн 2 дахь заалтад

заасны дагуу Монгол Улсын Ерөнхий сайд онцгой бүрэн эрхийнхээ хүрээнд Улсын Их Хурлын гишүүн Хассуурийн Ганхуягийг Монгол Улсын Шадар сайдаар томилох шийдвэр гаргаж танилцуулж байна аа.

Энэ шийдвэрийг Монгол Улсын Ерөнхийлөгчид 2025 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 121 тоот албан бичгээр хүргүүлж хариуг авсан. Сайнбуянгийн Амарсайханыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 103 дугаар зүйлийн 103.1 дэх хэсэгт заасны дагуу Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Шадар сайдын үүрэгт ажлаас чөлөөлөх болон Хассуурийн Ганхуягийг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Шадар сайдаар томилох асуудлыг Улсын Их Хуралд үүгээр танилцуулж байна аа.

Бүсчилсэн хөгжил, чөлөөт бүс, эдийн засгийн тусгай бүс, гамшгаас хамгаалах онцгой байдал стандартчилал хэмжил зүй зэрэг асуудал эрхэлсэн Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Монгол Улсын Шадар сайдаар томилох Хассуурийн Ганхуягийн дэлгэрэнгүй намтрыг Улсын Их Хуралд 2025 оны 11 дүгээр сарын 7-ны өдөр хүргүүлсэн.

Хассуурийн Ганхуяг нь олон улсын харилцааны мэргэжилтэй. Улсад 22 жил ажилласан. 2020 оноос Улсын Их Хурлын гишүүн, 2025 оноос Төсвийн байнгын хорооны даргаар ажиллаж байна. Тэрээр бүсчилсэн хөгжил, эдийн засгийн бодлого, тэр дундаа төсвийн бодлогын чиглэлээр үр дүн гаргаж ажилласан туршлагатай.

Эрхэм гишүүд ээ,

Дэлхийн улс төр, геополитик, эдийн засгийн тогтворгүй байдал, уур амьсгалын өөрчлөлт манай гадаад орчинд өөрчлөлт орж байгаа энэ үед Шадар сайд бас олон улсын Засгийн газар хоорондын комиссыг ахалж ажилладаг учраас яаралтай томилох ийм гадаад орчны шаардлагууд бий болж байна. Нөгөө талаас энэ уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалан гамшиг осол онцгой байдлын нөхцөл байдал, халдварт өвчний эрсдэл нэмэгдэж байгаа. Мөн өвөлжилт хүндрэх хүндэрч болзошгүй байгаа энэ цаг үед Монгол Улс ч гэсэн энэ гамшгийн эрсдэлийг бууруулж сөрөн тэсвэрлэх үндэсний чадавхыг бэхжүүлэх асуудал эн тэргүүнд тавигдаж байна.

Ялангуяа өвөлжилтийн бэлтгэлийг хангах, цаг уурын хүндрэл, зудын эрсдэл, гамшиг ослоос ард иргэд ААН-ийн хэвийн үйл ажиллагаанд болзошгүй гэнэтийн эрсдэлийг урьдчилан сэргийлэх асуудлууд бас чухлаар тавьж байна. Тиймээс Засгийн газар иргэдийн аюулгүй орчныг бүрдүүлэх онцгой байдлын чадавхыг нэмэгдүүлэх, гамшгийн эрсдэлийг бууруулах, бэлэн байдлаа цаг ямагт анхаарах ёстой. Мөн бүсчилсэн хөгжлийг эрчимжүүлэх бүс нутаг бие даан хөгжих төсвийн эрмэлзэлтэй болж нэгдсэн бодлого төлөвлөлттэйгөөр бодит үр дүнд хүрэхэд олон ажлуудыг хийх шаардлагатай байна аа.

Түүнчлэн Монгол Улсын Шадар сайд нь Монгол Улс, ОХУ, Монгол Улс-Узбекистан, Монгол Улс-Киргизийн Засгийн газар хоорондын хамтарсан комиссууд, мөн Монгол Британийн дугуй ширээний уулзалтыг ахалж ажилладаг.

Өнгөрсөн 9 дүгээр сард Монгол Улсын Ерөнхийлөгч ШХАБ-ын гишүүн орнуудын төрийн тэргүүн нарын хуралдаанд оролцож, БНХАУ-ын дарга Си

Жиньпинтэй 2 талын уулзалт хийж мөн хөршүүдтэй 3 талын уулзалт хийж тодорхой асуудлуудаар тохиролцоонд хүрсэн.

Дээрх уулзалт хуралдааны хүрээнд ярилцаж хэлэлцсэн асуудлуудыг бодит ажил хэрэг болгох, түлш шатахуун, цахилгаан эрчим хүчний хангамжийн тогтвортой байдлыг хангах зэрэг шийдвэрлэх шаардлагатай олон асуудлууд бас хүлээгдэж байна. Ийм учраас энэ асуудлуудыг хариуцсан Засгийн газрын гишүүн, Шадар сайдыг яаралтай томилох шаардлага үүссэн.

Ийм учраас Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Шадар сайдыг нэн яаралтай томилох шаардлагад нийцүүлэн өнөөдөр яаралтай горимоор танилцуулахаар бас их Улсын Их Хуралд тэргүүлснийг танилцуулж байгаа Улсын Их Хурлын даргын дэргэдэх зөвлөлд талархаж байна.

Хассуурийн Ганхуягийн мэргэжлийн туршлага удирдан зохион байгуулах чадвар ажил эрх чанарыг нь үнэлж энэхүү хариуцлагын албан тушаалд итгэл хүлээлгэн томилохоор шийдвэрлэж Улсын Их Хуралд танилцуулж байгаа.

Монгол Улсын сайд ард иргэдийн итгэлийг дааж хэлсэн үг хийсэн ажилдаа эзэн байх өндөр хариуцлагыг хүлээж ажиллах учиртай.

Иймд Ерөнхий сайд миний бие Засгийн газрын бүх гишүүддээ хандан төрийн үйл хэрэгт хоёргүй сэтгэлээр зүтгэж Үндсэн хуульт эрх зүйт төрийг батлах үүргээ ухамсарлан танхимын зарчмаар хамтран ажиллах зарчмыг хатуу баримталж ажиллахыг үүрэг болгож байгаа.

Ингээд сайдын танилцуулгыг танилцуулж дууслаа.

Мөнх хөх тэнгэрийн хүчин дор Монгол орон мандан бадрах болтугай.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Б.Пүрэвдорж:** Нэг зүйлийг бас тодруулж хэлье.

Улсын Их Хурлын тухай Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 25.8-д Ерөнхий сайд Засгийн газрын гишүүний албан үүргийг хавсран гүйцэтгэж байгаа гишүүн Байнгын, дэд, хянан шалгах түр хорооны даргаар ажиллахгүй гэдэг энэ заалтын дагуу Монгол Улсын Их Хурлын байнгын хорооны албан бланк дээр

Монгол Улсын Их Хурлын дэд дарга танаа

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.9. дэх хэсэгт заасныг үндэслэн Төсвийн байнгын хорооны даргын албан үүргээ Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяад түр хариуцуулж байна.

Хүндэтгэсэн Төсвийн байнгын хорооны дарга Х.Ганхуяг гэсэн байна аа.

Энэ 25.9 биш шүү. 25.8 шүү. 25.9 чинь байхгүй хооронд гэж байгаа юм 7 хоног. Та өөрөө томилогдоод энэ 25.8-аар томилогдож явж байгаа учраас энэ бичгээ дахиж сольж өгөөрэй.

Тийм учраас нөгөө яг энэ асуултаар гишүүд асуух хэрэггүй гэж үзсэний үндсэн дээр тайлбарлаж хэлж байна.

Ерөнхий сайд болон томилогдох этгээдээс асуулт асууж үг хэлэх Улсын Их Хурлын гишүүн нэрээ өгнө үү? Лутаагийн Энхнасан гишүүнээр тасаллаа. Аюушийн Ариунзаяа гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

**А.Ариунзаяа:** Пүрэвдорж гишүүний сая уншсан өргөдөлтэй холбоотойгоор Баттөмөрийн Энхбаяр гэдэг сайд Тусгай хяналтын дэд хорооны даргаа хэвээрээ хийж байгаа энэ ажлаа өгөөгүй байгаа. Хууль зөрчиж байгаа гэдгийг бас энэ дашрамд дурдмаар байна. Хууль зөрчсөн гэснээс Хассуурийн Ганхуяг төсвийг базахдаа зөвхөн лааз гэхээсээ илүүтэй ер нь бол маш олон хуулиудыг зөрчсөн байгаа шүү.

Төсвийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төрийн аудитын тухай хууль, Төрийн хөгжлийн бодлогын тухай хууль маш олон хуулиудыг зөрчсөн ийм төсөв өнөөдөр батлагдлаа. Тэгээд яг сайдаар ажиллахдаа 1 дүгээрт хууль тогтоомжоо маш сайн мөрддөг байгаасай. Сая баталж байгаа төсвийн бүхий л алдаа оноо бол Засгийн газар дээр ирнэ. Тэгээд багш эмч нарынхаа цалин хөлсийг нэмэгдүүллээ гэсэн ам, амлалт өгч байгаа боловчиг төсөв нь бол бүрэн бүтэн суугаагүй. Тэгэхээр төсвийн тодотгол орж ирж таарна. Маш их зураг төсөв, зураг эдийн засгийн үндэслэл тооцоололгүй хууль зөрчсөн хөрөнгө оруулалтад тавигдсан. 5 сарын 1-ээс өмнө татагдахаар байгааг бас анхаарч Засгийн газар одоогоос эхлээд төсвийн тодотгол дээрээ ажиллах нь зүйтэй гэж энэ дашрамд бас хэлмээр байна. Төсөв дээр хориг орж ирдэггүй л юм бол төсвийн тодотгол гарцаагүй орж ирэх учиртай гэдгийг бол хэлье.

Тэгээд Хассуурийн Ганхуяг маш үнэтэй их үнэ цэнээр л энэ сайдын суудал дээр ирж байна. Тэгээд л амжилт хүсдэг л байх даа. Амжилт хүсье.

**Б.Пүрэвдорж:** Аюушийн Ариунзаяа гишүүн үг хэллээ.

Одоо Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан гишүүн үг хэлж, асуулт асууна.

**Л.Мөнхбаясгалан:** Та давхар дээл тэгэхдээ бас нэлээн хүнд давхар дээл өмсөх болж байна. Тэгэхээр танд захих үг байгаа юм. Яамдууд чинь аж ахуйн ажил хийдэг боллоо. Ганхуяг дарга аа тэрийг та мэдэж байгаа тиймээ? Бодлого боловсруулах ёстой яамдууд аж ахуйн алба хийгээд байгаа юм. Энэ ерөөсөө болохгүй. Тэгэхээр нөгөө бодлого боловсруулалт чинь алдагдсан.

Дээрээс нь их замбараагүй байгаа. Одоо жишээ нь зөвхөн усны асуудал гэхэд 5 яаманд харьяалагдаж байх жишээний ийм байгаа юм. Тэгэхээр нөгөө захиргааны ерөнхий бүдүүвчээ бас эргэж харах цаг болсон юм шиг санагдаж байгаа юм. Та бол уул уурхайн мэргэжилтэй хүн юм байна. Тэгэхээр та бол гаднын хөрөнгө оруулагч нартай дотоодынхоо уул уурхайн компаниудтай учраа олоод ажиллачих байх. Нэг зүйлийг битгий мартаарай. Уул уурхайгаас Монгол Улс санхүүжиж байгаа нь үнэн. Гэхдээ та байгаль орчныг, байгаль орчны сэдвийг, дээрээс нь энэ усыг хэзээ ч битгий мартаарай. Монголын төр байгаль орчин унаган байгалиа хамгаалах ёстой. Усаа авч үлдэх ёстой. Бэлчээрээ авч үлдэх ёстой. Цөлжилтийн эсрэг ажиллах ёстой. Энийг анхаардаг тийм Шадар сайд байгаарай гэж захъя.

Дээрээс нь Ганхуягаа. Дараа нь баяр хүргээч. Та би түрүүн хэлсэн тиймээ. Яамдууд аж ахуйн ажил хийгээд байна. Зарим сайд нар чинь мөрдөн байцаагчийн ажил хийж байна. Бүүр шоронгийн хуягийн ажил хийдэг боллоо. Энийг болиулмаар байна аа. Сайд бол ерөөсөө л бодлого боловсруулдаг хүн байх ёстой байхгүй юу. Тэрнээс биш хүн мөрддөг, шалгадаг, хүнийг гүтгэдэг тийм байх ёсгүй шүү. Улс төрийн ороо бусгаа байдал одоо ингээд дуусах ёстой. Энэ дээрээ анхаарч эв нэгдлийг нэлээн сайн дэмжиж хангаж ажиллаарай гэж хүсье.

Зөвхөн яамдууд сайд нар бодлого л боловсруулдаг байх ёстой. Өс хонзонгоор ажил хийдэг зарим хүмүүсийг тэрийг нь болиулна биз дээ. Тэгээд амжилт хүсье.

**Б.Пүрэвдорж:** Одоо. Лутаагийн Энхнасан гишүүн асуулт асууж, үг хэлнэ. Гишүүдэд энэ оройн амар амгаланг айлтгая. Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудалд Бүсийн хөгжлийн хөтөлбөр, бодлого эдийн засгийн тусгай бүсийн хөгжлийн нэгдсэн бодлого, стандартчилал мөн чөлөөт бүсийн асуудал бас орж байгаа. Тэгээд Монгол Улсад эдийн засгийн чөлөөт бүс байгуулах үзэл баримтлал 95 оноос баталсан. Тэгээд үе үеийн Засгийн газар яг чөлөөт бүсийг хөгжүүлэх энэ зорилгыг дэвшүүлсэн байгаа. Гэвч энэ ажил өнөөг хүртэл удаашралтай байгаа.

Тэгэхээр харин шинээр томилогдож байгаа Шадар сайдыг бас энэ чөлөөт бүсийн асуудлыг бас анхаарч ажиллаач ээ гэж хүсэж байна. Мөн өмнө нь бүсийн хөгжлийн асуудал, стандартчилал энэ асуудлыг бас орхигдуулахгүй ажиллана аа гэдэгт итгэж байна. Өнөөдөр бас Засгийн газрын хуралдаанаар нэг чухал асуудал орсон байна лээ. Энэ бол Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж нийлүүлэлтийг дэмжих тухай хуулийн төсөл Улсын Их Хуралд өргөн баригдаж байгаа юм билээ. Тэгээд энэ Алтанбулаг, Цагаан нуур, чөлөөт бүсэд газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөцийг агуулах Замын-Үүд хүнсний болон тасралтгүй нөөцөөр хангах энэ шаардлагатай бараа бүтээгдэхүүний улсын нөөцийн агуулах сав барих ийм шаардлага байгаад байгаа. Тэгээд энэ асуудлыг бас сайд анхаарч ажиллана гэж итгэж байна аа. Тэгээд өөрт чинь амжилт хүсье ээ.

**Б.Пүрэвдорж:** Үг хэллээ. Даваагийн Цогтбаатар гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

**Да.Цогтбаатар:** Гишүүдийнхээ энэ өдрийн амгаланг айлтгая аа.

Өмнө Улсын Их Хурлын гишүүн Төсвийн байнгын хороон дээр Ганхуяг гишүүнтэй 2 жил орчим хугацаанд хамтарч ажиллаж байгаа. Зарчимч байгаа байдлыг бол үнэлж байсан. Өмнөх 2 сайд яг энэ Шадар сайдаар ажиллаж байсан буюу энэ мэргэжлийн хяналт онцгой байдлыг хариуцаж байсан сайд нар бараг мэргэжлийн түвшинд очиж ажиллаж байсан. Хүрэлсүх Ерөнхийлөгч, Амарсайхан сайд хоёр хоёулаа маш удаан хугацаанд ч энэ ажлыг хийсэн байх. Тэгээд тэр түвшинд таныг бас нэг зориглоод хүрч ажиллаасай гэж захиас хэлэх гэсэн юм. Одоо ган зуд болно, гал ус болно. Манай Монгол залуучууд ер нь бараг гар нүцгэн шахуу л тулж ордог энэ салбар сүүлд бол энэ Францтай хамтраад, Франц улстай хамтраад маш сайн хамтын ажиллагаа хөгжүүлээд шинэ технологи нисдэг тэрэг ч гэдэг юм уу нисгэгчээ энэчээнээ бэлтгэх ч гэдэг юм уу ингээд асуудлууд маш сайн явж байгаа. Энийг та бас яг ингэж төсөв бага байгаа гэж чамлахгүйгээр шинэ шинэ хөрөнгө оруулалтыг яаж олдог юм, энэ салбарт нэг та үлгэр жишээ үзүүлээд өгөөсэй гэж хүсэж байгаа.

Хоёрдугаарт, энэ мал малчид чинь бас ер нь бол бараг эзэнгүй хаягдчихсан л улс болчихсон шүү дээ. Ган зуд болдог хөөрхий муу малчид руу тэгээд нөгөө онцгойгийнхон зам харгуй гаргана гээд л явдаг. Тэгээд энэ дээр бас нэлээн сайн сүүлийн үеийн техник технологи дэвшлийг ашиглаад мал малчид руугаа хэрхэн ойртох хамгийн наад захын жишээ энэ сүлжээний асуудлууд маш муу явж байгаа. Улс орон даяараа бид нар чинь 150 гаран багууд нь сүлжээгүй явж байна уу. 280 байна уу? Эдгээр асуудлуудыг бас шийдэхгүй бол бид нар зөвхөн нэг ойр зуурын асуудлуудаар нь хөөцөлдөөд байж болохгүй байх аа гэж бодож байгаа.

Тэгэхээр та бол энэ онцгой байдлын салбар одоо жишээлэхэд Өвөрхангай аймгийн Хархорин сумд баригдаж байгаа аврах ангийн байшин энэ төсвийнх нь асуудлаас болоод хойшлогдчихож байна. Баянхонгор аймагт баригдаж байгаа онцгой байдлын байшин хугацаа нь дуусаад нурчихсан. Тэгээд бид нар сая барья гэдэг асуудал яригдаад орж ирэхэд дахиад сая төсөв нь хөрөнгө оруулалтаараа хасагдчихаж байгаа. Та өөрөө энэ хасах ажлуудыг хийсэн. Тэгээд эдгээрийгээ маш хурдан хугацаанд хийхгүй бол онцгой байдлын салбар бол үнэхээр хүнд нөхцөлд байгаа шүү гэдгийг танд захиж хэлж байгаа шүү тэгээд амжилт хүсье.

**Б.Пүрэвдорж:** Даваагийн Цогтбаатар гишүүн үг хэллээ. Цэвэгдоржийн Туваан гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

**Ц.Туваан:** Оройн мэнд. Монгол Улсын ерөнхий сайдын бүрэн эрхийн хэрээнд Шадар сайдын томилгоо явж байна. Тэгээд дэмжиж ажиллана аа. 2026 оны улсын төсөв батлагдлаа. Тэгээд яах вэ мэдээж бас л нэлээн амаргүй зам туулж батлагдлаа. Энэ дээр бас тойрогт ажиллаад иргэдтэй уулзахаар нэг зүйл яригдаж байгаа юм. Одоо энэ багш нарын асуудал. Яах вэ бага сага ч гэсэн ингээд шийдэгдэнэ, эмч нарын асуудал бас шийдэгдэнэ. Хөгжлийн бэрхшээлтэй хүний, тусгай хэрэгцээтэй иргэдийн асуудал шийдэгдэнэ. Ахмадын тэтгэвэр гээд. Энэ хүмүүс, байгууллагууд дотор чинь тэр ТҮ-ийнхэн гэж улсууд байгаа. Сургуульд ч байгаа, эмнэлэгт ч байгаа энэ улсуудын бас цалин хангамжтай холбоотой нийгмийн асуудалтай холбоотой асуудлыг бас төсөв батлагдсан энэ өдөр анхаарч, дараагийн удаад энэ хүмүүсийн нийгмийн баталгаа, цалин цавуутай холбоотой асуудлыг хөндөж тавина шүү гэдэг зүйлийг бас хэлчихмээр санагдаж байна.

Онцгой байдлын асуудал хариуцаж байгаагийн хувьд 2, 3 зүйл хэлье. Энэ онцгой байдалд ажиллаж байгаа хүмүүсийг ерөөсөө тушаал өгөөд л ингээд л ажиллуулдаг. Зарим үед бол үнэхээр хүчин мөхөстдөг. Тоног төхөөрөмж байхгүй, гал хөсөнд орно, ус руу орно, хувцас хунар юм хум байхгүй. Тэгэхээр энэ зүйлүүдийг нэгэнт л тушаал өгөөд онцгой үер ус байгалийн гамшгийн өөдөөс явж байгаа юм бол энэ хүмүүсийнхээ энэ техник, тоног төхөөрөмжийн асуудлыг нь нэлээн бодож үзэж ажиллаарай. Гар хоосон байдаг юм байна лээ шүү. Өнгөрсөн жил төвийн бүс дээр олон газар түймэртэй байсан. Онцгойгийнхон л очсон. Тэгээд л бас л гар нүцгэн л явж байсан. Тэгэхээр энэ асуудлыг анхаараарай дээрээс нь сая Монгол оронд бас нэлээн олон газруудад гангийн эрсдэл үүссэн. Энэ онцгой нөхцөл байдал үүссэн.

Үүнээс болж тариаланчид, ногоочид ургац алдсан. Тэгээд ингээд эргээд энэ гамшгийн нөхцөл байдлыг тогтоох асуудал яригдаад энэ шийдэл олдохгүй ингээд эзэнгүй болоод ингээд дуусдаг. Үнэхээр ган болчихсон ямар ч техник, ямар ч нөхцөл байгаад давж гарах аргагүй ийм нөхцөлүүдтэй тулдаг. Тэгэхээр энийг нэг эзэнтэй болгож шийдлийг нь гаргаж тэр ган, зудын эрсдэл нөхцөлийг нь тооцож гаргаад

ингээд тэр хүмүүст төр байвал нэг хүнд үед нь бас нэг гараа сунгах асуудлыг бас ярьж баймаар байгаа юм.

Тэгэхээр энэ асуудал бол онцгой байдал дээр хамаарна аа. Тэр эрэн хайх аврах бүлэг гээд нэг сумдууд дээр нэг хүмүүсийг бий болгочихсон. Нэг машинтай 31 зогсож байгаа 5, 6 хүн байгаа. Цалин цавуу байхгүй л гэж байсан. Тэгэхдээ арай ч байхгүй байна гэж байхгүй байлгүй. Тэгэхээр энэ хүмүүс чинь ялгаагүй яг л зуд болоод л эрсдэл үүсэхэд хамгийн түрүүнд л явдаг. Тэгэхээр энэ аврах бүлгийн хүмүүсийн асуудлыг та бас анхаарч үзээрэй. Энийг нэг сөхөж хараарай гэдгийг хэлье. Тэгээд сүүлд нь нэг асуулт асуучихъя. Энэ таны эрхлэх асуудлын хүрээнд энэ бүсчилсэн хөгжлийн бодлого явж байгаа. Тэгээд 1 хэсэг бид нар явсан. Хуульдаа өөрчлөлт оруулаад сонгуулиа бид нар энүүгээр хийсэн. Тэгээд одоо сүүлийн үед нэг л яригдахаа больчихлоо. Тэгэхээр таны хувьд яг энэ бүсчилсэн хөгжлийн бодлогыг авч явах Монгол Улсын хөгжлийг бүсчилсэн хөгжлийн байдлаар цааш нь явуулна аа гэдэг дээр ямар бодлого барьж ажиллах вэ итгэл үнэмшил чинь байна уу гэдэг зүйлийг асууя.

**Б.Пүрэвдорж:** Нэр дэвшигч Хассуурийн Ганхуяг асуултад хариулна.

**Х.Ганхуяг:** Бүсчилсэн хөгжлийн бодлогыг бол бид нар 2020-2024 оны хооронд энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хийхдээ ер нь суурь концепцыг нь хийсэн л дээ. Ер нь үзэл баримтлалын хувьд. Тэгээд сая энэ 2024-2025 онуудад бид нар бол яг энэ бүсчилсэн хөгжилтэй холбоотой ТЭЗҮ, зураг төсвийн мөнгийг нь уг нь бас олгож өгсөн юм. 2026 оны төсөв дээр хамгийн анх удаагаа яг бүсчилсэн хөгжлийн тэр зураг төсөвтэй холбоотой асуудлаар нь бид нар хөрөнгө оруулалтын анхны юуг нь тавьж өгч байгаа. Яг улсын төсөв дээр. Одоо манай АН-аас ажлын хэсэгт орсон гишүүд ч бүгдээрээ мэдээлэлтэй байгаа. Улсын Их Хурлын манай Ардын намын гишүүд ч бүгдээрээ мэдээлэлтэй байгаа. Яах вэ уг нь бол 180 тэрбум төгрөгийн төсөв санхүүжих өртөгтэй төслүүдийг 2026 онд санхүүжүүлэе гэсэн. Тэгэхдээ яалт ч үгүй улсын төсөв хүнд байгаа болохоор буураад 96 тэрбумаар орж байгаа төсөвт өртөг нь 2 зуугаад тэрбум байх юм. Тэгэхээр ирэх жилээс бид нар яг энэ бүсчилсэн хөгжилтэй холбоотой хөрөнгө оруулалтуудаа хийгээд эхэлнэ ээ гэж харж байгаа.

Цаашдаа бид нар яалт ч үгүй бүсчилсэн хөгжлийг гол бодлогоо болгож явахгүй л бол энэ болохгүй байгаа шүү дээ. Бид нар чинь хүний нөөцийн асуудал байна, зах зээлийн асуудал байна. Нийгмийн үйлчилгээний асуудал байна. Дэд бүтцийн асуудал байна. Энийг сум сумаараа биш болж өгвөл бүсчлээд магадгүй дараа нь тэр зах зээлтэй холбоотойгоор бид нар сумуудаа багасгах ч байдаг юм уу ийм боломжууд тэрний дараа л бүрдэх байх. Тэр хүртэл бид нар ингээд аль болох том том бүсүүдээ бий болгох энэ тал дээрээ л бодлогоо барьж явах ёстой л доо.

**Б.Пүрэвдорж:** Буланы Бейсен гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

**Б.Бейсен:** Шадар сайдаар томилж байгаа Ганхуяг гишүүнд баяр хүрээд ажлын амжилт хүсье. Хамтарч ажиллана гэдгээ хэлье. Таны хариуцаж байгаа алба нэлээн хүнд хүнд салбарууд байгаа. Ялангуяа онцгой байдлын асуудал, энэнтэй холбоотой та бүгд мэдэж байгаа энэ жил баруун аймаг зудын хүнд байдалтай байгаа. Баян-Өлгий, Ховд, Увс аймгууд. Хивэг 45 мянга хорголжин хивэг. Пресс өвс 25 хүрчихсэн байгаа. Энийг үнийг нь нэмэгдэхээс өмнө арга хэмжээ авах шаардлагатай байгаа. Гурилын асуудал байгаа. Энэ жил түрүүн бид Байнгын

хороогоор хуралдаад ХААЯ-ны сайдад чиглэл өгөөд Засгийн газар хурлаар ороод хэлэлцэгдсэн. Одоо ингээд Их Хурлын хороогоор одоод батлагдах асуудал байгаа бас. Шийдүүлэхгүй л бол бид 2 бас энэ үнэд орох гээд байна. Манайхаас сонгогдсон энэ залуу гишүүд түрүүн попроод Засгийн газар нөгөө энэ хил гаалийн татварыг чөлөөлчихлөө гэсэн. Одоо ард иргэд нар барьж идэх гэж байна.

Тийм учраас энэ дээр нэг онцгой анхаарлаа хандуулж ажиллаарай гэдгийг хэлье. Нөгөө талаар Цагааннуурын чөлөөт бүсийн асуудал байгаа. Урд хил, гааль, боомтын сайд энэний зураг төсвийг нь гаргуулаад Цагааннуур боомтыг өргөтгөх асуудал байгаа. Энэ дээр бас онцгой анхаарал хандуулаад 24 цагаар ажиллуулах тал дээр бас анхаарах уу гэдгээ хэлье. Бензин сая Баян-Өлгий аймагт 130 төгрөг нэмэгдсэн. Сая хилийн цаанаас ойрхон газар орж ирдэг мөртөө 130 төгрөг нэмэгдсэн. Алслагдсан газар 4 мянга төгрөг байгаа шүү дээ энэ түлш чинь. Энийг шийдүүлээд ер нь энэ үнийг буулгах талын асуудал дээр бас та анхаарах байх гэж бодож байна.

Бусад асуудлууд манай гишүүд бас хамтраад хэлэх байх. Тийм учраас энэ асуудал дээр онцгой анхаараад ажиллаарай гээд хэлье. Нөгөө талаар өнөөдрийн энэ төсөв дээр онцгой байдлын байр худалдан авах гээд тэрбум 408 сая төгрөг тавигдсан байна. Тэр хуучин ногоон нуурын тэжээлийн аж ахуйн байр байгаа юм балгас болчихсон. Энийг уг нь ХААЯ-ны сайдтай ярьж байгаад тэжээлийн нөөц ногоон нуурт газар тариалан хөгжүүлээд дахиж сэргээх асуудал байсан. Тэгэхдээ онцгой байдал руу сая оруулж байх шиг байна. Уг нь 700 хэдэн сая гэж байсан сая өндөр үнээр худалдаж авч байна. 1 сая 408 саяар та газар дээр нь очоод үзээрэй. Ямар лобби орсныг мэдэхгүй байна. Тийм учраас энийг цаашдаа тэр онцгой байдлын тэжээл, өвс тэжээл бэлтгэх чиглэлээр энийг ашиглавал зүгээр байна гэдэг хэлье. Тэгээд танд ажлын амжилт хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Б.Пүрэвдорж:** Үг хэллээ. Гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууслаа.

Монгол Улсын Засгийн газрын гишүүнийг огцруулах, томилох тухай асуудлыг Монгол Улсын Ерөнхий сайд Улсын Их Хуралд танилцууллаа.

12.22 цаг

Засгийн газрын гишүүн Улсын Их Хуралд тангараг өргөх тухай асуудал 10 минутын дараа, 19.40 гэхэд танхимд явагдана.

Тэгээд гишүүдийг 10 минут завсарлуулъя.

Дараагийн асуудалд оръё.

**Засгийн газрын гишүүн Улсын Их Хуралд тангараг өргөнө.**

Монгол Улсын Ерөнхий сайд Гомбожавын Занданшатар Засгийн газрын гишүүнээр томилсон тухай захирамжийг уншиж танилцуулна.

Индэрт урьж байна.

**Г.Занданшатар:** Монгол Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн 39 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 23 дугаар зүйлийн нэг дэх хэсгийн 2 дахь заалтын дагуу Монгол Улсын Ерөнхий сайд бүрэн эрхийнхээ дагуу Улсын Их Хурлын гишүүн Хассуурийн Ганхуягийг Монгол Улсын Монгол Улсын Ерөнхийлөгч Монгол Улсын Их Хуралд танилцуулж Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Шадар сайдаар томилж батламжилж байна аа.

Захирамжийг өнөөдөр сая баталж Монгол Улсын Засгийн газрын гишүүн Шадар сайдаар Улсын Их Хурлын гишүүн Хассуурийн Ганхуягийг томилсугай гэсэн захирамжийг та бүхэнд танилцуулж байна.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Б.Пүрэвдорж:** Ерөнхий сайдад талархлаа.

Засгийн газрын гишүүн тангараг өргөх ёслолын ажиллагааг эхэлье.

Монгол Улсын Засгийн газрын гишүүн Монгол Улсын Шадар сайд Хассуурийн Ганхуяг таныг тангараг өргөхийг урьж байна аа.

**Х.Ганхуяг:** Монгол Улсын Засгийн газрын гишүүн би улсынхаа ашиг сонирхлыг эрхэмлэн, төрт ёс түүх соёлынхоо уламжлалыг хүндэтгэж Монгол Улсын Үндсэн хуулийг дээдлэн сахиж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж төрийн хууль биелүүлэх ажлыг төр, ард түмэн, Монгол Улсын Ерөнхий сайдын өмнө биечлэн хариуцаж, Засгийн газрын гишүүний үүргээ чин шударгаар биелүүлэхээ тангараглая аа.

Миний бие энэ тангаргаасаа няцвал хуулийн хариуцлагыг хүлээхэд бэлэн байна аа.

**Б.Пүрэвдорж:** Засгийн газрын гишүүн Улсын Их Хуралд тангаргаа өргөлөө.

Танд баяр хүргэж ажлын амжилт хүсье. Тангараг өргөх ёслолын ажиллагаа өндөрлөснийг мэдэгдье.

Өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан өндөрлөснийг мэдэгдье ээ.

19.38 цагт

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ  
БУУЛГАЖ, ХЯНАСАН:ШИНЖЭЭЧ П.МЯДАГМАА